



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2024 оны 08 дугаар сарын 12
№30 (1326)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

492.	Хүүхэд хамгааллын тухай /Шинэчилсэн найруулга/	2649
493.	Хүүхэд хамгааллын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	2756
494.	Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2757
495.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2766
496.	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2770
497.	Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2772
498.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай	2776
499.	Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2778
500.	Хууль зүйн туслалцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2779
501.	Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай	2780
502.	Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	2781

503.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай		2782
504.	Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		2783
505.	Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай		2787
506.	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		2788
507.	Конвенц соёрхон батлах тухай		2789
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ			
508.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 02	2790
МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ			
509.	Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенц		2792



᠒᠔᠔	<p style="text-align: center;">ᠨᠢᠪᠡᠳᠦᠷᠭ᠎ᠠ ᠲᠤᠯᠤᠯᠤᠰ</p> <p>ᠨᠢᠪᠡᠳᠦᠷᠭ᠎ᠠ ᠲᠤᠯᠤᠯᠤᠰ /ᠨᠢᠪᠡᠳᠦᠷᠭ᠎ᠠ ᠲᠤᠯᠤᠯᠤᠰ/</p>	᠒᠔᠔
᠒᠔᠕	ᠨᠢᠪᠡᠳᠦᠷᠭ᠎ᠠ ᠲᠤᠯᠤᠯᠤᠰ ᠲᠤᠯᠤᠯᠤᠰ	᠒᠔᠕
᠒᠔᠖	ᠨᠢᠪᠡᠳᠦᠷᠭ᠎ᠠ ᠲᠤᠯᠤᠯᠤᠰ ᠲᠤᠯᠤᠯᠤᠰ	᠒᠔᠖
᠒᠔᠗	ᠨᠢᠪᠡᠳᠦᠷᠭ᠎ᠠ ᠲᠤᠯᠤᠯᠤᠰ ᠲᠤᠯᠤᠯᠤᠰ	᠒᠔᠗
᠒᠔᠘	ᠨᠢᠪᠡᠳᠦᠷᠭ᠎ᠠ ᠲᠤᠯᠤᠯᠤᠰ ᠲᠤᠯᠤᠯᠤᠰ	᠒᠔᠘
᠒᠔᠙	ᠨᠢᠪᠡᠳᠦᠷᠭ᠎ᠠ ᠲᠤᠯᠤᠯᠤᠰ ᠲᠤᠯᠤᠯᠤᠰ	᠒᠔᠙
᠒᠕᠐	ᠨᠢᠪᠡᠳᠦᠷᠭ᠎ᠠ ᠲᠤᠯᠤᠯᠤᠰ ᠲᠤᠯᠤᠯᠤᠰ	᠒᠕᠐
᠒᠕᠑	ᠨᠢᠪᠡᠳᠦᠷᠭ᠎ᠠ ᠲᠤᠯᠤᠯᠤᠰ ᠲᠤᠯᠤᠯᠤᠰ	᠒᠕᠑

Հ040.	<p>Չստացրած զինքն զ զինքն օրհնակ զինքն զինքն զինքն զինքն Идея& Фою_ 02 Фола фою_ 02 КЕ* 1</p>	Հ24Գ
Հ040.	<p>Կարծիք զինքն զինքն զինքն Идея& Фою_ 02 YkE Hor& 02 Doedeg&</p>	Հ24Ը
Հ020.	<p>Գոյնը Կարծիք զինքն զինքն Идея& Կարծիք զինքն զինքն</p>	Հ24Ը
Հ050.	<p>Կարծիք զինքն զինքն զինքն Идея& Կարծիք զինքն զինքն</p>	Հ24Ը
Հ050.	<p>Կարծիք զինքն զինքն զինքն Идея& Կարծիք զինքն զինքն</p>	Հ24Ը
Հ050.	<p>Կարծիք զինքն զինքն զինքն Идея& Կարծիք զինքն զինքն</p>	Հ24Ը
Հ040.	<p>Կարծիք զինքն զինքն զինքն Идея& Կարծիք զինքն զինքն</p>	Հ24Ը
Հ090.	<p>Կարծիք զինքն զինքն զինքն Идея& Կարծիք զինքն զինքն</p>	Հ24Ը



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 01 дүгээр
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилго

1.1.Энэ хуулийн зорилго нь хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, хүүхэд хамгаалалд оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлох, хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдэд шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэх замаар хүүхдийн аюулгүй байдал, хүүхдийн хамгаалуулах эрх, хүүхдийн сайн сайхан байдлыг хангахад оршино.

2 дугаар зүйл.Хүүхэд хамгааллын хууль тогтоомж

2.1.Хүүхэд хамгааллын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Хүүхдийн эрхийн тухай хууль², Гэр бүлийн тухай хууль³, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль⁴, Нийгмийн халамжийн тухай хууль⁵, Боловсролын ерөнхий хууль⁶, Эрүүл мэндийн тухай хууль⁷, Хөдөлмөрийн тухай хууль⁸, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3.Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаар тогтоосон хуулийн хэм хэмжээ зөрчилдвөл хүүхдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг хэрэглэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

¹ Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

² Хүүхдийн эрхийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2016 оны 09 дугаарт нийтлэгдсэн.

³ Гэр бүлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1999 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2017 оны 05 дугаарт нийтлэгдсэн.

⁵ Нийгмийн халамжийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2012 оны 08 дугаарт нийтлэгдсэн.

⁶ Боловсролын ерөнхий хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2023 оны 27 дугаарт нийтлэгдсэн.

⁷ Эрүүл мэндийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2011 оны 21 дугаарт нийтлэгдсэн.

⁸ Хөдөлмөрийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2021 оны 31 дугаарт нийтлэгдсэн.

3.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга болон түр оршин сууж байгаа хүүхэд Монгол Улсын харьяат эсэхээс үл хамааран энэ хуулийн үйлчлэлд хамаарна.

3.2.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд Монгол Улсын хилийн гадна байгаа Монгол Улсын харьяат хүүхдэд энэ хууль үйлчилнэ.

3.3.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд 18-21 хүртэл насны хүнд энэ хуульд заасан тусламж, үйлчилгээг үзүүлж болно.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“хүүхдийн сайн сайхан байдал” гэж хүүхдийн бие махбод, эрүүл мэнд, сэтгэл санаа, нийгэмшихүй, танин мэдэхүй, боловсрол, эдийн засгийн хэрэгцээ, шаардлага хангагдсан, хүүхдийн хөгжлийг дэмжсэн орчин нөхцөлийг;

4.1.2.“хүүхэд хамгаалал” гэж нийгмийн бүх орчинд хүүхэдтэй зүй бус харьцах, хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөөс хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн энэ хуульд заасан зарчмыг баримталсан цогц бодлого, үйл ажиллагаа, үйлчилгээг;

4.1.3.“хүүхдийн эсрэг хүчирхийлэл”/цаашид “хүчирхийлэл” гэх/ гэж хүүхдийн хэвийн өсөлт, хөгжил, эрүүл мэнд, аюулгүй байдалд хор хохирол учруулах, бие махбод, сэтгэл санаа, эдийн засаг, бэлгийн дарамт, хүчирхийллийн үйлдэл, эс үйлдэхүйг;

4.1.4.“эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэж дараах хүүхдийг ойлгоно:

4.1.4.а.амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин алдагдсан хүүхэд;

4.1.4.б.хүчирхийлэлд өртсөн, эсхүл өртөх нөхцөлд байгаа хүүхэд;

4.1.4.в.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй хүүхэд;

4.1.4.г.гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдалд байгаа хүүхэд.

4.1.5. “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхэд” гэж дараах хүүхдийг ойлгоно:

- 4.1.5.а.гэмт хэрэг, зөрчлийн хохирогч, гэрч хүүхэд;
- 4.1.5.б.өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч;
- 4.1.5.в.зөрчилд холбогдогч хүүхэд;
- 4.1.5.г.зөрчил үйлдэж шийтгэгдсэн, эрүүгийн

хариуцлага хүлээсэн, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхэд;

4.1.5.д.иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа хүүхэд.

4.1.6. “хүүхдийг үл хайхрах” гэж хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, үүрэг хүлээсэн бусад этгээд хүүхдийн аюулгүй байдал, бие махбод, эрүүл мэнд, сэтгэл санаа, боловсрол, хөгжлийн хэрэгцээг гачигдуулсан, асран хамгаалах үүргээ биелүүлээгүйн улмаас хүүхдийг эрсдэлт нөхцөлд оруулсныг;

4.1.7. “гэмт хэрэг, зөрчлийн хохирогч хүүхэд” гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль⁹, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль¹⁰ заасны дагуу хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсон хүүхдийг;

4.1.8. “үе тэнгийн дээрэлхэлт” гэж нэг буюу хэд хэдэн хүүхэд өөр нэг буюу хэд хэдэн хүүхдийг бие махбод, сэтгэл санааны хувьд гэмтээх, зовоох, ялгаварлан гадуурхах, айлган сүрдүүлэх, заналхийлэх зорилготой түрэмгий зан үйлээ санаатайгаар, удаа дараа биеэр, амаар болон цахим орчинд үйлдэхийг;

4.1.9. “хүүхэд хамгааллын үйлчилгээ” гэж хүүхэд хамгааллын тогтолцооны оролцогч талуудаас хүүхдийн хамгаалуулах эрхийг хангах зорилгоор үзүүлж байгаа шуурхай тусламжийн, хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээг;

4.1.10. “хүүхдийн эрхийн хууль зүйн хороо” гэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдэд шаардлагатай тусламж, үйлчилгээ үзүүлэх талаар шийдвэр гаргах, уг шийдвэрийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий орон нутгийн орон тооны бус нэгжийг;

⁹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 23 дугаарт нийтлэгдсэн.

¹⁰ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.



4.1.11.“хамтарсан баг” гэж Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5.1.4-т заасныг;

4.1.12.“асралт гэр бүл” гэж энэ хуульд заасан үндэслэлээр гэр бүлээсээ тусгаарлагдсан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг гэрээнд заасан хугацаанд асран халамжилж байгаа хүүхдийн төрөл, садны биш гэр бүлийг;

4.1.13.“кейс менежмент” гэж хүүхэд, гэр бүлд чиглэсэн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг тодорхой үе шатаар хүргэх, зохицуулах, хяналт тавих мэргэжлийн үйл ажиллагааг;

4.1.14.“хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлага” гэж хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж байгаа нийгмийн ажлын мэргэжилтнийг онол, арга зүйн хувьд удирдан чиглүүлэх, дэмжих, зөвлөн туслах, хөгжүүлэх үйл ажиллагааг;

4.1.15.“хориотой агуулга” гэж хуулиар хориглосон контент, бүтээл, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааг;

4.1.16.“хүүхдэд хортой агуулга” гэж хуулиар хориглоогүй боловч хүүхдийн эрүүл мэнд, нас, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшил, хүмүүжилд сөргөөр нөлөөлөх контент, бүтээл, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааг.

5 дугаар зүйл.Хүүхэд хамгааллын зарчим

5.1.Хүүхэд хамгаалалд дараах зарчмыг баримтална:

5.1.1.хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол, аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавих;

5.1.2.хүүхдийн үзэл бодол, саналаа илэрхийлэх эрх, оролцоог хангах;

5.1.3.хүүхэд хамгаалал нь тогтолцоонд суурилсан, гэр бүл төвтэй, олон талт, цогц, мэргэшсэн, дагнасан, шуурхай, хүртээмжтэй, үр дүнтэй байх;

5.1.4.хүүхдийг гэр бүлээс нь тусгаарласан тохиолдолд нэн тэргүүнд төрөл, садны гэр бүлийн асрамжид байлгахыг эрмэлзэх, хүүхдийг ах, эгч, дүүтэй нь хамт байлгах;

5.1.5.төр хүүхдийг хамгаалахдаа хүүхдийн аюулгүй, сайн сайхан байдлыг хангах зорилгод хүрэхэд зайлшгүй, тохирсон арга хэмжээ авах;



5.1.6.хүүхдийн нөхцөл байдал, ялгаатай онцлогийг хүлээн зөвшөөрөх, хүүхдийн нэр төрийг хүндэтгэх.

5.2.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхэдтэй шууд харьцаж ажилладаг болон бусад хүнд хүүхдийг хүмүүжүүлэх, хүүхэдтэй харилцахдаа бие махбодын шийтгэл хэрэглэх, гутаан доромжлохыг хориглоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

6 дугаар зүйл.Хүүхэд хамгааллын үйлчилгээний хэлбэр

6.1.Хүүхэд хамгааллын үйлчилгээ дараах хэлбэртэй байна:

- 6.1.1.шуурхай тусламжийн үйлчилгээ;
- 6.1.2.хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ;
- 6.1.3.урьдчилан сэргийлэх үйлчилгээ.

7 дугаар зүйл.Шуурхай тусламжийн үйлчилгээ

7.1.Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар мэдээлэл хүлээн авсан, өөрөө илрүүлсэн сум, баг, хорооны Засаг дарга, цагдаагийн алба хаагч, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан хүүхэд аюултай нөхцөл байдалд орсон бол хүүхдэд шуурхай тусламжийн үйлчилгээг үзүүлж, аюулыг зайлуулах, аюул учруулах нөхцөл байдлыг арилгах арга хэмжээг нэн даруй авна. Шаардлагатай гэж үзвэл хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр аюултай нөхцөл байдал арилах хүртэл аюулгүй газар түр байрлуулж болно.

7.2.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хүүхэд аюултай нөхцөл байдалд орсон бол Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30.1-д заасан арга хэмжээг авч, хүүхдийг гэр бүлээс нь түр хугацаагаар тусгаарлах арга хэмжээг авна. Энэ тохиолдолд хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрлийг шаардахгүй.

7.3.Шуурхай тусламжийн үйлчилгээний хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, эмнэлгийн яаралтай тусламж, сэтгэл зүйн болон хууль зүйн анхан шатны зөвлөгөө, сэтгэл заслын үйлчилгээнд нэн даруй холбон зуучилна. Шаардлагатай тохиолдолд хүүхдийг хамгаалах аюулгүйн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.



7.4.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хүүхэд аюултай нөхцөл байдалд ороогүй нь аюулын зэргийн болон эрсдэлийн үнэлгээгээр тогтоогдсон бол хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүлээлгэн өгнө.

Тайлбар:Энэ зүйлд заасан “хүүхэд аюултай нөхцөл байдалд орсон” гэж хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюул заналхийлсэн, хүүхдийн зан байдал нь өөрийн, эсхүл бусдын амь нас, эрүүл мэндэд аюул учруулахаар нөхцөл байдалд байгааг ойлгоно.

8 дугаар зүйл.Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ

8.1.Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг гэр бүлийн болон гэр бүлээс нь тусдаа орчинд гэсэн хэлбэрээр үзүүлнэ.

8.2.Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний хүрээнд дараах үйлчилгээг үзүүлнэ:

8.2.1.хүүхдийг асрах, өсгөн хүмүүжүүлэх талаар зөвлөгөө өгөх, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх;

8.2.2.сэтгэл зүйн цочрол, хямрал, гэмтлээ даван туулахад нь туслах сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх;

8.2.3.хүүхдийн эсрэг хүчирхийллээс үүдэлтэй хүүхдийн зан авирын өөрчлөлтөд чиглэсэн нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх;

8.2.4.хүүхдийг суралцах, төлөвших, авьяасыг хөгжүүлэх зорилгоор хүүхдийн хөгжлийн онцлог, хэрэгцээнд тохирсон сургалт, үйл ажиллагаанд хамруулах, холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх;

8.2.5.хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх;

8.2.6.сургууль завсардсан хүүхдийн чадвар, хөгжлийн онцлог, сонирхлыг судалж, зохих боловсролын байгууллагад холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх;

8.2.7.хүүхэд, эцэг, эхийн харилцааг сайжруулах, харилцааны зөрчил, хямралыг шийдвэрлэх сургалтад хамруулах;

8.2.8.хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдэд Хөдөлмөрийн тухай хуульд заасан нөхцөл, шаардлагад нийцүүлэн хөнгөн ажил, хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх, аюултай, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэлтэд өртөхөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх;



8.2.9.амьжиргааны нөхцөлийг сайжруулах зорилгоор гэр бүлд тусламж, дэмжлэг үзүүлэх, ажлын байранд холбон зуучлах;

8.2.10.нийгмийн халамжийн үйлчилгээнд хэрхэн хамрагдах талаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэхэд нь тусалцаа үзүүлэх;

8.2.11.архи, согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй ажиллах тусгай хөтөлбөр гаргаж, үйлчилгээнд хамруулах;

8.2.12.хүчирхийллийн харилцаатай эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг зан үйлд нөлөөлөх албадан болон сайн дурын хөтөлбөрт хамруулах;

8.2.13.хүүхэд үрчилж авсан эцэг, эхэд эцэг, эхийн үүрэг, хариуцлага хүлээлгэх, үрчлэлтийг хүчингүйд тооцсон тохиолдолд хүүхдийн эрхийг хамгаалах, тусалцаа үзүүлэх;

8.2.14.гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлж байгаа хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээ үзүүлэх;

8.2.15.хууль тогтоомжид заасан бусад.

8.3.Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг энэ хуулийн 18.3-т заасан хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөөний дагуу үзүүлнэ.

8.4.Энэ хуулийн 8.2-т заасан хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг нэгэн зэрэг хослуулан үзүүлж болно.

8.5.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага болон 18-21 хүртэл насны хүн зөвшөөрсөн тохиолдолд түүнд 21 нас хүртэл нь хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлж болно.

8.6.Сэтгэл зүйн үйлчилгээний стандарт, бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд үзүүлэх хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

**9 дүгээр зүйл.Гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах,
нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх**

9.1.Гэр бүлийн орчинд үзүүлэх хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үр дүнд хүрээгүй, эсхүл уг үйлчилгээг гэр бүлийн орчинд үзүүлэх нь хүүхдийн эрхэд хор хохирол учруулахаар байгаа тохиолдолд гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлнэ.

9.2.Гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэхдээ дараах хүүхэд асрах хувилбарт үйлчилгээг ашиглана:

9.2.1.хүүхдийг төрөл, садны гэр бүлд асруулах;
9.2.2.хүүхдийг асралт гэр бүлд асруулах;
9.2.3.асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамруулах.

9.3.Хүүхдийг хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамруулах, үйлчилгээг өөрчлөх эсэхийг шийдвэрлэхдээ долоон нас хүрсэн хүүхдийн санал, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага болон хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны дүгнэлтийг авна.

9.4.Сум, дүүргийн Засаг дарга, эсхүл хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага хүүхдийг хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамруулах хүртэл хугацаанд хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30.1-д заасан арга хэмжээг урьдчилан авч болно.

9.5.Хүүхдийг хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамруулахдаа хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолтой зөрчилдөхөөс бусад тохиолдолд ах, эгч, дүүтэй нь хамт байлгана.

9.6.Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9.7.Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

9.8.Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний явцад сум, дүүргийн Засаг дарга, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага хяналт тавина.

10 дугаар зүйл.Хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлах үндэслэл

10.1.Дараах үндэслэлээр хүүхдэд гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлнэ:

10.1.1.эцэг, эх хоёулаа нас барсан;
10.1.2.шүүхийн шийдвэрээр эцэг, эх хоёулаа нас барсан,
эсхүл сураггүй алга болсонд тооцогдсон;

10.1.3.эцэг, эх хоёулаа шүүхийн шийдвэрээр иргэний эрх
зүйн чадамжгүйд, эсхүл хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон;

10.1.4.шүүхийн шийдвэрээр эцэг, эх байх эрхийг
хязгаарласан, хассан;

10.1.5.эцэг, эх хоёулаа удаан хугацаагаар эмнэлэгт
эмчлүүлж байгаа, цагдан хоригдсон, хорих ял эдэлж байгаа зэрэг
шалтгаанаар хүүхдээ биечлэн асран хамгаалах, тэжээн тэтгэх боломжгүй
болсон;

10.1.6.эцэг, эх хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүүхдээ
хамгаалах, асран хүмүүжүүлэх, тэжээн тэтгэх үүргээ удаа дараа
биелүүлээгүй;

10.1.7.эцэг, эх хүүхдийнхээ эсрэг хүчирхийлэл үйлдсэний
улмаас хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, хөгжилд эрсдэл учирсан.

10.2.Гэрлэлт цуцлуулсан болон хуульд заасан бусад үндэслэлээр
хүүхдийг асрамжид авсан эцэг /эх/-т энэ хуулийн 10.1-д заасан үндэслэл
бий болсон нь хүүхдэд гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах, нөхөн
сэргээх үйлчилгээг үзүүлэхэд нэгэн адил үйлчилнэ.

10.3.Хүүхдийг энэ хуулийн 10.1.5, 10.1.6, 10.1.7-д заасан
үндэслэлээр гэр бүлээс нь тусгаарлаж, хүүхэд асрах хувилбарт
үйлчилгээнд хамруулсан бөгөөд хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх
боломжгүй тохиолдолд эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах асуудлыг
Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

10.4.Энэ зүйлд заасан үндэслэлээр гэр бүлээсээ тусгаарлагдаж,
хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн хөрөнгө,
өвлөгдөх хөрөнгөд эрхлэн хамгаалалт тогтоож, хяналт тавих асуудлыг
холбогдох хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

11 дүгээр зүйл.Хүүхдийг төрөл, садны гэр бүлд асруулах

11.1.Хүүхдийг төрөл, садны гэр бүлд асруулах эсэхийг тухайн
гэр бүлээс бичгээр зөвшөөрөл авч, гэр бүлийн нөхцөл байдалд үнэлгээ
хийсний үндсэн дээр шийдвэрлэнэ.

11.2.Хүүхдийг төрөл, садны гэр бүлд асруулахаар асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоохтой холбогдсон бусад харилцааг Гэр бүлийн тухай хуулиар зохицуулна.

12 дугаар зүйл.Хүүхдийг асралт гэр бүлд асруулах

12.1.Асралт гэр бүл болох хүсэлт гаргасан хүний гэр бүлийн мэдээллийг харьяа хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага бүртгэн авч, тухайн гэр бүлийн нөхцөл байдалд үнэлгээ хийнэ. Нөхцөл байдлын үнэлгээгээр тухайн гэр бүл асралт гэр бүлийн үйлчилгээ үзүүлэх боломжтой нь тогтоогдсон тохиолдолд сургалтад хамруулж, гэрчилгээ олгоно.

12.2.Хүүхдийг асралт гэр бүлд асруулахаар шилжүүлэхдээ тухайн гэр бүлтэй орон нутгийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага хүүхэд асран хүмүүжүүлэх гэрээг байгуулна.

12.3.Хүүхэд асран хүмүүжүүлэх гэрээнд дараах зүйлийг тусгана:

12.3.1.хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох нөхцөлөөр хангах;

12.3.2.асран хүмүүжүүлэгчийн эрх, үүрэг;

12.3.3.хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын эрх, үүрэг;

12.3.4.асран хүмүүжүүлэгчид олгох урамшуулал, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу олгох бусад тэтгэмж, хөнгөлөлт;

12.3.5.асран хамгаалуулагчийн эд хөрөнгө;

12.3.6.гэрээний хугацаа, гэрээ цуцлах, дуусгавар болох үндэслэл, түүний үр дагавар.

12.4.Эд хөрөнгө, санхүү, эрүүл мэндийн байдлын хувьд хүүхдийг асран хүмүүжүүлэх боломжгүй, асран хүмүүжүүлж байсан хүүхдээ өөрийн буруугаас буцаан өгсөн, Гэр бүлийн тухай хуульд заасан асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоохыг хориглосон хүнтэй хүүхэд асран хүмүүжүүлэх гэрээ байгуулахыг хориглоно.

12.5.Хүүхдийг асралт гэр бүлд шилжүүлсний дараа тухайн гэр бүлд тааламжгүй нөхцөл бий болсон, хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн, хүүхдийг эрсдэлт нөхцөлд оруулсан, хүүхэд асран хүмүүжүүлэх гэрээг цуцлах үндэслэл бий болсон бол хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал



хариуцсан орон нутгийн байгууллага болон сум, дүүргийн Засаг дарга гэрээг нэн даруй цуцална.

12.6.Асралт гэр бүлд хүндэтгэн үзэх шалтгаан /өвчилсөн, гэр бүлийн болон эд хөрөнгийн байдал өөрчлөгдсөн, харилцан үл ойлголцох, маргаантай байдал/ бий болсон бол гэрээг хугацаанаас өмнө цуцалж болно.

12.7.Асралт гэр бүлд шилжүүлсэн хүүхэд тэжээгчээ алдсаны болон нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авах болон хууль тогтоомжид заасны дагуу бусад хангамжаар хангагдах эрх эдэлнэ.

13 дугаар зүйл.Хүүхдийг асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамруулах

13.1.Хүүхдийг энэ хуулийн 11, 12 дугаар зүйлд заасан үйлчилгээнд хамруулах боломжгүй тохиолдолд асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамруулна.

13.2.Хүүхдэд үзүүлэх асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээг гэр бүлтэй дүйцэхүйц орчинд болон бүлгийн хэлбэрээр зохион байгуулж хүргэнэ.

13.3.Хүүхдийг асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамруулахтай холбогдсон бусад харилцааг Нийгмийн халамжийн тухай хуулиар зохицуулна.

14 дүгээр зүйл.Урьдчилан сэргийлэх үйлчилгээ

14.1.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, хамтарсан баг, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан кейс менежмент, нотолгоонд суурилсан урьдчилан сэргийлэх хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлж, үр дүнг үнэлнэ.

14.2.Урьдчилан сэргийлэх үйлчилгээ дараах төрөлтэй байна:

14.2.1.зорилтот бүлэгт чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ;

14.2.2.олон талт, хамтарсан арга хэмжээ.

14.3.Урьдчилан сэргийлэх үйлчилгээ нь төрийн болон нутгийн захиргааны байгууллага, шүүх, хууль сахиулах байгууллага, хяналт шалгалтын чиг үүрэг бүхий байгууллагаас зохион байгуулах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилтай уялдсан байна.



14.4.Хуулийн этгээд хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил явуулах үүрэгтэй.

14.5.Урьдчилан сэргийлэх үйлчилгээг сайн дурын ажилтны болон хүүхдийн оролцоо, тусламжтайгаар зохион байгуулж болох бөгөөд уг ажилтныг бүртгэх, сургах ажлыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага зохион байгуулна.

14.6.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийттэй харилцах, соён гэгээрүүлэх чиглэлийн стратегийг боловсруулж батална.

Нэгдүгээр дэд бүлэг Кейс менежмент

15 дугаар зүйл.Кейс менежментийн үе шат

15.1.Хүүхэд хамгааллын үйлчилгээг кейс менежментийн дараах үе шатны хүрээнд үзүүлнэ:

15.1.1.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, харилцаа холбоо тогтоох;

15.1.2.хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдлыг үнэлэх;

15.1.3.хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөө гаргах;

15.1.4.хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх, зохицуулах;

15.1.5.хүүхэд хамгааллын үйлчилгээний явц, үр дүнг хянах, үнэлэх;

15.1.6.хүүхэд хамгааллын кейсийг хаах.

15.2.Урьдчилан сэргийлэх үйлчилгээг үзүүлэхэд энэ хуулийн 15.1-д заасан кейс менежментийн үе шат хамаарахгүй.

15.3.Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хүүхэд, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь монгол хэл мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлийн улмаас өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо илэрхийлэх чадвар хязгаарлагдмал бол орчуулагч, хэлмэрч заавал оролцуулна.

15.4.Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан хүүхэд хамгааллын кейсийг нээхээс хаах хүртэлх хугацаанд хүүхэд хамгааллын үйлчилгээний хүрээнд гарсан шийдвэр, үйл ажиллагааг холбогдох стандарт, маягт, зааврын дагуу заасан хугацаанд баримтжуулж, биет болон цахим хэлбэрээр хадгалж, мэдээллийн санд оруулна.

15.5. Хүүхэд хамгааллын үйлчилгээг хүүхдийн тухайн оршин байгаа газрын хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага үзүүлнэ. Хүүхэд хамгааллын кейсийг шийдвэрлэх явцад хүүхдийн оршин байгаа газар өөрчлөгдсөн тохиолдолд хүүхэд хамгааллын кейсийг харьяаллын дагуу хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага руу шилжүүлнэ.

15.6. Шуурхай тусламжийн үйлчилгээ, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхээр бүртгэсэн хүүхэд бүрийг хүүхэд хамгааллын нэг кейс гэж үзэх бөгөөд кейс тус бүр бүртгэл, дугаартай байна.

15.7. Энэ дэд бүлгээр зохицуулаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж, стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан нийгмийн ажлын үйлчилгээний стандартаар зохицуулна.

16 дугаар зүйл. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх

16.1. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэхэд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, сум, баг, хорооны Засаг дарга санал, санаачилга гаргах, хүүхэд болон хүн, хуулийн этгээдээс гомдол, мэдээлэл хүлээн авах зэрэг боломжит бүх аргыг ашиглана.

16.2. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн хүн, хуулийн этгээд энэ талаар хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, сум, баг, хорооны Засаг дарга, хүүхдэд яаралтай тусламж үзүүлэх утасны үйлчилгээнд нэн даруй мэдээлэх үүрэгтэй.

16.3. Ажил, мэргэжлийн болон сайн дурын үйл ажиллагааны явцад хүүхэдтэй шууд харилцаж байгаа хүн эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар мэдээлэх үүрэгтэй бөгөөд энэ нь түүний ёс зүйн дүрэм, гэрээ, хэлцлээр хүлээсэн үүргээс давуу үйлчилнэ.

16.4. Энэ зүйлд заасан мэдээ, мэдээллийг хүлээн авах, илрүүлэх зорилгоор яаралтай тусламжийн 24 цагийн утас ажиллуулна.

17 дугаар зүйл. Мэдээлэл өгөгчийг нууцлах

17.1. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар мэдээлэл өгсөн этгээд өөрийнхөө тухай мэдээллийг бусдад өгөхийг зөвшөөрснөөс бусад тохиолдолд уг этгээдийн хувийн мэдээллийг нууцална.



17.2. Хүүхэд өөрөө тусламж авахаар хандсан тухай хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид мэдэгдэх нь хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй тохиолдолд мэдээллийг нууцална.

17.3. Энэ зүйлд заасан мэдээллийг нууцлахад мэдээллийн эх сурвалж, мэдээлэл өгөгчийн хувийн мэдээллийг хамгаалах, бусдад задруулахаас сэргийлэх арга хэмжээ авч ажиллана.

18 дугаар зүйл. Нөхцөл байдлын үнэлгээ хийх, төлөвлөгөө гаргах

18.1. Хүүхдэд тохирох хүүхэд хамгааллын үйлчилгээг тодорхойлох зорилгоор нөхцөл байдлын үнэлгээ хийнэ. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан нөхцөл байдлын үнэлгээ хийхдээ шаардлагатай тохиолдолд хамтарсан баг, эсхүл холбогдох мэргэжилтний тусалцааг авч болно.

18.2. Нөхцөл байдлын үнэлгээг хийхдээ хүүхдийн бие бялдар, эрүүл мэнд, сэтгэл зүй, зан авир, танин мэдэхүй, нийгэмшихүй, боловсролын байдал, гэр бүл, сургалтын орчин, хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүүхэд өсгөх ур чадвар, тэдний хоорондын харилцаа зэрэг нөхцөл байдлыг нягтлан судална.

18.3. Нөхцөл байдлын үнэлгээгээр хүүхдэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх шаардлагатай нь тогтоогдсон бол хүүхэд, түүний гэр бүлийн орчин, нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөө гаргана.

18.4. Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөөнд хэрэгжүүлэх хугацаа, оролцогч талуудын хамтын ажиллагаа, тэдгээрийн ажил, үүргийн хуваарилалт, харилцан мэдээлэл солилцох журам, алслагдмал газар, засаг захиргааны нэгжид оршин суудаг хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээг явуулын хэлбэрээр хүргэх зэрэг асуудлыг тусгана.

18.5. Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөөг хамтарсан багийн ахлагч болон төлөвлөгөөг боловсруулсан этгээд баталгаажуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

18.6. Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулахад хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, долоон нас хүрсэн хүүхдийн саналыг авна.

18.7. Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөөг харьяа хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажлын албанд хүргүүлнэ.



18.8.Нөхцөл байдлын үнэлгээ хийх журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

18.9.Нөхцөл байдлын үнэлгээ хийсэн хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, хамтарсан багийн гишүүнд хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын нормативын дагуу урамшуулал олгоно.

19 дүгээр зүйл.Хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх, зохицуулах

19.1.Хүүхэд хамгааллын үйлчилгээг энэ хуулийн 18.3-т заасан төлөвлөгөөний дагуу үзүүлнэ.

19.2.Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэхдээ хүүхэд, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хамтарсан багийн гишүүн, оролцогч талуудын санал, дүгнэлтийг авах, тэдэнтэй ганцаарчилсан болон хамтарсан уулзалт, зөвлөгөөн хийх, шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах, оролцогч талуудын үйл ажиллагааг зохицуулж ажиллана.

20 дугаар зүйл.Хүүхэд хамгааллын үйлчилгээний явц, үр дүнг хянах, үнэлэх

20.1.Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөөнд заасан зорилго, зорилт, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд үндэслэн явцын болон эцсийн үнэлгээг хийнэ. Хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн саналыг үнэлгээнд тусгана.

21 дүгээр зүйл.Хүүхэд хамгааллын кейсийг хаах

21.1.Хүүхэд хамгааллын кейсийг дараах үндэслэлээр хаана:

21.1.1.хүүхэд хамгааллын үйлчилгээний зорилго биелэгдэж, хүүхдийн сайн сайхан байдал хангагдсан;

21.1.2.хүүхэд 18 насанд хүрсэн бөгөөд 21 нас хүртэл хүүхэд хамгааллын үйлчилгээ авахыг зөвшөөрөөгүй;

21.1.3.хүүхэд үрчлэгдсэн;

21.1.4.хүүхэд нас барсан.

21.2.Хүүхэд хамгааллын кейсийг хаахад харьяа хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагад танилцуулж, зөвшөөрөл авна.

21.3.Хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэсэн тохиолдолд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан улирал тутам нөхцөл байдлын үнэлгээ хийж, хоёр жил хүртэл хугацаанд хяналт тавина.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ГЭР БҮЛ, НИЙГМИЙН ОРЧИН ДАХЬ ХҮҮХЭД ХАМГААЛАЛ

22 дугаар зүйл.Гэр бүл дэх хүүхэд хамгаалал

22.1.Эцэг, эх хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, асран хамгаалахдаа түүний нас, бие, сэтгэхүйн онцлогт тохирсон хүчирхийллээс ангид хүмүүжлийн эерэг арга хэрэглэж, хүүхдэд зөвлөн тусална.

22.2.Эцэг, эх хүүхдийн эрхийг хамгаалах, гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авна.

22.3.Эцэг, эх хүүхдийн амьдарч байгаа орчны эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлийг арилгах, гэр бүлийн хүрээнд хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.

22.4.Эцэг, эхэд хүүхэдтэй холбоотой эрхээ урвуулан ашиглах, хүүхдийг үл хайхрах, зүй бус харьцах, бие махбодын шийтгэл хэрэглэх, гутаан доромжлохыг хориглоно.

22.5.Эцэг, эх хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд хүүхдээ хөдөлмөр эрхлэхийг зөвшөөрөх, хүүхдийн оюун ухаан, биеийн хөгжил, амь нас, эрүүл мэндэд аюул учруулах өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллуулахыг хориглоно.

22.6.Эцэг, эх хүүхдийн эрх, нэр төрд сөргөөр нөлөөлөх мэдээлэл, дуу, дуу-дүрсний, дүрсний бичвэр, гэрэл зургийг бусдад дамжуулах, цахим орчинд байршуулахыг хориглоно.

22.7.Эцэг, эх энэ хуульд заасан хүүхэд хамгааллын үйлчилгээ авахаар хүсэлт гаргах, зөвлөгөө, мэдээлэл авах, хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөс бусад тохиолдолд хүүхэд хамгааллын үйлчилгээнд оролцох, хамтран ажиллах эрхтэй.

22.8.Хүүхдийн дэргэд согтууруулах ундаа хэрэглэх, эсхүл хэрэглэсэн үедээ хүүхдийн амьдарч, суралцаж байгаа орчин, орон байранд нэвтэрснийг хүүхдийг эрсдэлт нөхцөлд оруулсантай адилтгаж үзэж болно.

22.9.Энэ зүйл хүүхдийн асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нэгэн адил үйлчилнэ.

23 дугаар зүйл.Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал

23.1.Боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төв, сүм хийдийн шашны сургууль хүүхэд хамгааллын бодлого, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна.

23.2.Энэ хуулийн 23.1-д заасан байгууллагын орчин, дотуур байранд хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлж, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

23.2.1.хүүхдийг амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй сургалт, үйл ажиллагаанд оролцуулахгүй байх;

23.2.2.хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авах;

23.2.3.хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтийн талаар гомдол, мэдээлэл хүлээн авах нээлттэй суваг ажиллуулах;

23.2.4.гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд холбогдсон болон хохирогч хүүхдийг хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамруулах;

23.2.5.хүүхдийг хорт зуршил, согтуурах, мансуурах, донтох байдалд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авах;

23.2.6.багш, ажилтан, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг хүүхдийн эрх, хүүхэд хүмүүжүүлэх зэрэг арга зэмшүүлэх талаар сургалтад хамруулах, зөвлөгөө өгөх;

23.2.7.хичээлийн жилийн турш хүүхэд эрсдэлт нөхцөлд байгаа эсэхийг үнэлэх, зөвлөгөө өгөх, хүүхэд бүрийн нийгэм, сэтгэл зүйн асуудлыг илрүүлэх, тандан судлах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх;

23.2.8.сургалтын байгууллагын барилга байгууламжид зөвшөөрөгдсөн байршилд хуульд заасны дагуу хяналтын камер байршуулах, сургуулийн орчны замын хөдөлгөөнд хурд сааруулагч, аюулгүйн тэмдэг, тэмдэглэгээ хийлгүүлэх;

23.2.9.сургалтын орчны нөхцөл байдлын зураглал гарган эрсдэлийн үнэлгээг улирал тутам хийх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх;

23.2.10.хүүхэд хоорондын болон хүүхэд, багш, ажилтан, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хоорондын харилцаанаас үүссэн зөрчил, хүүхдэд тулгарсан бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх;

23.2.11.хүүхэд, түүний гэр бүлийн гишүүдийн хүний хувийн болон эмзэг мэдээллийг хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд аливаа этгээдэд мэдээлэх, задруулахгүй байх;

23.2.12.хүүхэд тодорхойгүй шалтгаанаар хичээлдээ ирээгүй тохиолдолд гэр бүл, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нэн даруй мэдэгдэх;

23.2.13.хүүхэд эрсдэлт нөхцөлд өртсөн талаар мэдсэн, таамагласан, илрүүлсэн бол харьяа хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд мэдэгдэх.

23.3.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сургуулийн багш, ажилтан, сэтгэл зүйч, сайн дурын ажилтан сургуулийн орчин, дотуур байранд хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртсөн талаар мэдсэн, таамагласан, илрүүлсэн бол тухайн боловсролын сургалтын байгууллагын захирал, сургуулийн нийгмийн ажилтанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

23.4.Боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төв энэ хуулийн 23.3-т заасан мэдээллийг хүлээн авч, дараах арга хэмжээг авна:

23.4.1.хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагад мэдэгдэх, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлт нь гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй байвал холбогдох эрх бүхий этгээдэд мэдэгдэх;

23.4.2.хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтийн талаар мэдээлсэн суралцагчийн мэдээллийн нууцыг хадгалах, цаашид хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

23.4.3.хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд холбогдсон болон хохирогч суралцагчийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй уулзалт зохион байгуулах, зөвлөгөө, мэдээлэл өгөх;

23.4.4.хохирогч хүүхдийг сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээнд нэн даруй хамруулах;



23.4.5.хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлт үйлдсэн хүүхдэд дараах арга хэмжээг шат дараалан хэрэглэх:

23.4.5.а.суралцагчид өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах, зөвлөгөө өгөх, хохирогч суралцагчаас уучлалт гуйлгуулах;

23.4.5.б.сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээг үзүүлэх, хүүхдийн төлөвшилд нөлөөлөх сургалт, үйл ажиллагаанд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамт хамруулах.

23.5.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүүхэд хамгааллын чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

23.5.1.боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг батлах;

23.5.2.боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдээллийн сан бүрдүүлэх;

23.5.3.боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвийн сургалтын хөтөлбөрт эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх ур чадварыг эзэмшүүлэх агуулга туссан эсэхэд хяналт тавих.

23.6.Боловсролын сургалтын байгууллага, сүм хийдийн дотуур байранд байрлаж байгаа хүүхдийн эрхийн хэрэгжилтэд тухайн орон нутгийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага аймгийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэстэй хамтран хяналт тавина.

23.7.Гадаад улсад шашны байгууллага /сургууль/-д суралцаж байгаа хүүхдийн эрхийн хэрэгжилтэд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хяналт тавина.

23.8.Боловсролын сургалтын байгууллага, сүм хийдийн орчны аюулгүй байдалд нөхцөл байдлын үнэлгээ хийх журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

23.9.Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний нийтлэг шаардлагыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.



23.10.Боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвд суралцаж байгаа хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдлын тандалт судалгааг гурван жил тутам Боловсролын ерөнхий хуулийн 17.2-т заасан байгууллага хийнэ.

23.11.Боловсролын ерөнхий хуулийн 40.2.8-д заасан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн төлөөллийн байгууллага хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын төлөвлөгөөтэй байна.

24 дүгээр зүйл.Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгаалал

24.1.Эрүүл мэндийн байгууллага эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

24.2.Эрүүл мэндийн ажилтан ажил, үүргээ гүйцэтгэх явцад эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн тохиолдолд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, эсхүл цагдаагийн байгууллага, хүүхдийн тусламжийн утсанд нэн даруй мэдээлнэ.

24.3.Эрүүл мэндийн байгууллага эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд харьяалал харгалзахгүй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ. Эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээг гэр бүлийн хүчирхийллийн болон гэмт хэргийн хохирогч хүүхдэд харьяалал, дараалал харгалзахгүйгээр шууд үзүүлнэ.

24.4.Эрүүл мэндийн ажилтан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад мэдсэн хүүхэд, түүний гэр бүлийн гишүүний хүний хувийн болон эмзэг мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан шаардсанаас бусад тохиолдолд бусдад дамжуулах, мэдээлэхийг хориглоно.

24.5.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүүхэд хамгааллын чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

24.5.1.эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг батлах;

24.5.2.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээллийн сан бүрдүүлэх;

24.5.3.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, яаралтай болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн ажилтан, эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, давтан сургалт зохион байгуулах.



25 дугаар зүйл.Хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин дахь хүүхэд хамгаалал

25.1.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч гэр бүлийн орчинд, боловсролын сургалтын байгууллага сургуулийн болон дотуур байрны орчинд, хуулийн этгээд хуульд заасан эрх эдэлж, үүргээ хэрэгжүүлэхдээ хүүхдийг эрүүл мэнд, оюун санаа, хүмүүжил, төлөвшилд нь сөргөөр нөлөөлөх бүх төрлийн хориотой, хүүхдэд хортой агуулгаас хамгаална.

25.2.Хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц цахим тоглоом, хүүхдэд хортой агуулга, цахим сүлжээнээс хүүхдийг хамгаалах талаар зөвлөмж, зааварчилгааг олон нийтэд түгээх, хэрэгжилтэд нь хяналт тавих чиг үүргийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороо, цагдаагийн төв байгууллага хэрэгжүүлнэ.

25.3.Хүн, хуулийн этгээд хүүхдийг цахимаар урхидах, дээрэлхэх, дарамтлахыг хориглоно.

25.4.Хүн, хуулийн этгээд хүүхдийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон, эсхүл хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр хүүхдийн зураг, дуу, дуу-дүрсний бичлэг агуулсан контент, мэдээ, мэдээлэл, бүтээлийг олон нийтэд түгээхийг хориглоно.

25.5.Хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчны үйлчилгээ эрхлэгч өөрийн үйлчилгээнд хориотой агуулгыг түгээхгүй байх, хүүхдэд хортой агуулгыг хянах, хязгаарлах, хаах арга хэмжээ авах үүрэгтэй.

25.6.Интернэтийн үйлчилгээ эрхлэгч эрх бүхий байгууллагын дүгнэлт, шийдвэрийн дагуу цахим орчинд түгээсэн хүүхдэд хортой болон хориотой контентыг өөрийн сүлжээнд хязгаарлалт хийх технологийн арга хэмжээг авна.

25.7.Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч контент, бүтээлийг олон нийтэд түгээхийн өмнө насны ангиллын тэмдэглэгээг байршуулна.

25.8.Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч хүүхдийг хориотой, хүүхдэд хортой агуулгаас хамгаалах зорилгоор насанд хүрэгчдэд зориулсан тохиргоог идэвхжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

25.9.Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч Харилцаа холбооны зохицуулах хорооны мэдэгдэлд заасан хориотой, хүүхдэд хортой агуулгыг өөрийн үйлчилгээнд хязгаарлах, хаах үүрэгтэй.

25.10.Хүн, хуулийн этгээд хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчинд хориотой агуулга түгээснээс хүүхдийн эрх зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй гэж үзвэл гомдлоо хүүхдийн эрхийн улсын байцаагч, цагдаагийн байгууллагад гаргаж, шийдвэрлүүлнэ.

25.11.Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

25.12.Хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хортой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл ажиллана.

25.13.Энэ хуулийн 25.12-т заасан орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар батална.

Тайлбар:Энэ зүйлд заасан “цахим орчны үйлчилгээ эрхлэгч” гэж цахим хуудас, цахим хэрэглүүр /аппликэйшн/, платформ, цахим орчин ашиглаж контент, бүтээлийг олон нийтэд хүргэх үйлчилгээ үзүүлэгч этгээдийг ойлгоно.

Энэ зүйлд заасан “цахимаар урхидах” гэж хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд уруу татах зорилгоор цахим сүлжээ ашиглан хүүхэдтэй харилцаа тогтоохыг ойлгоно.

Энэ зүйлд заасан “цахимаар дээрэлхэх” гэж цахим орчинд хүүхдийг дээрэлхэж, гадуурхсан, айлган сүрдүүлсэн, доромжилсон зүй бус агуулга бүхий мэдээ, мэдээллийг өөрт нь болон бусдад түгээхийг ойлгоно.

Энэ зүйлд заасан “цахимаар дарамтлах” гэж хүний хувийн болон эмзэг мэдээллийг ашиглан цахим орчинд хүүхдэд түгшүүр төрүүлэх, шахалт үзүүлэх үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

26 дугаар зүйл.Олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээ дэх хүүхэд хамгаалал

26.1.Худалдаа, үйлчилгээ, олон нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал, цуглаан, замын хөдөлгөөн, хүүхэд оролцсон шалгалт, уралдаан



тэмцээний үед хүүхдийг эрсдэлт нөхцөлд орох, осол, гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх үүргийг зохион байгуулагч болон оролцогч талууд хүлээнэ.

26.2.Энэ хуулийн 26.1-д заасан арга хэмжээ, үйлчилгээний үед хүүхдийн эрх зөрчигдсөн гэж үзсэн хүн, хуулийн этгээд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, цагдаагийн байгууллага, хүүхдийн тусламжийн утсанд мэдэгдэх үүрэгтэй.

26.3.Жагсаал, цуглааны үеийн хүүхэд хамгааллын стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

26.4.Олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээнд оролцож байгаа хүүхдийн аюулгүй байдалд хүүхдийн эрхийн улсын байцаагч, цагдаагийн байгууллага хяналт тавина.

26.5.Сум, дүүргийн Засаг дарга, хүүхдийн эрхийн улсын байцаагч худалдаа, үйлчилгээний газар, боловсролын сургалтын байгууллагаас гадуурх сургалтын ажил эрхэлдэг иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хүүхдийн эрх зөрчигдөж байгаа эсэхэд хяналт тавьж, хүүхдийг эрсдэлт нөхцөлд оруулсан бол уг үйл ажиллагааг хязгаарлах, зогсоох арга хэмжээ авна.

27 дугаар зүйл.Соёл, спортын үйл ажиллагаан дахь хүүхэд хамгаалал

27.1.Соёл, спортын үйл ажиллагаа, урлагийн тоглолт, спортын тэмцээн, бусад арга хэмжээнд хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр түүний хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхгүй орчинд оролцуулна.

27.2.Хүүхдийг соёл, спортын үйл ажиллагаа, урлагийн тоглолт, спортын тэмцээн, бусад арга хэмжээнд оролцуулахдаа сургалтын үйл ажиллагааг тасалдуулахгүй байх, хоцрогдлыг арилгах арга хэмжээг авна.

27.3.Сургалтын үйл ажиллагааг тасалдуулахгүй байх, хоцрогдлыг арилгах арга хэмжээг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, арга хэмжээнд оролцуулсан этгээд хамтран сургалтын хөтөлбөр, агуулгын хүрээнд, төрийн байгууллагаас улс, бүс, орон нутгийн хэмжээнд зохион байгуулж байгаа арга хэмжээнд хүүхэд оролцсон бол сургуулийн удирдлага тус тус зохион байгуулна.



27.4.Соёл, спортын үйл ажиллагаа, урлагийн тоглолт, спортын тэмцээний болон бэлтгэлийн үед багш, дасгалжуулагч нь хүүхдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үүрэгтэй.

27.5.Хурдан морины уралдаан болон морины сунгаа, уралдааны бэлтгэлийн үед уяач уралдаанч хүүхдийн эрх, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах хүрээнд дараах үүргийг хүлээнэ:

27.5.1.уралдаанч хүүхдийн сурч боловсрох эрхийг хязгаарлахгүй байх;

27.5.2.уралдаанч хүүхдийг эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулж, өсөлт, хөгжлийн талаар дүгнэлт гаргуулах;

27.5.3.уралдаанч хүүхдийг Үндэсний их баяр наадмын тухай хуульд¹¹ заасны дагуу батлагдсан стандартын шаардлага хангасан хамгаалалтын хувцас, хэрэгслээр хангах;

27.5.4.уралдаанч хүүхдийг хурдан морины уралдаан болон морины сунгаа, бэлтгэлийн үеийг хамруулсан ослын даатгалд даатгуулах;

27.5.5.уралдаанч хүүхдийн эрүүл мэндэд хохирол учирсан, амь нас, эрүүл мэндэд хохирол учрах нөхцөл байдал бий болсон тохиолдолд хүүхдийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд нэн даруй хамруулах;

27.5.6.уралдаанч хүүхдийг нэг өдөр хоёроос дээш удаа хурдан морь унуулж уралдуулахгүй байх. Энэ заалт хурдан морины уралдааны бэлтгэл үе шатанд хамаарахгүй;

27.5.7.уралдаанч хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, урамшуулал, бай, шагналыг тусгасан гэрээг бичгээр, эсхүл хуульд нийцүүлэн цахим хэлбэрээр байгуулах.

27.6.Хурдан морины уралдаанд уралдах морийг унах хүүхдийн нас Үндэсний их баяр наадмын тухай хуулиар тогтоосон наснаас доогуур байж болохгүй.

27.7.Хурдан морины уралдаанд уралдах морийг унах хүүхдийг ослын даатгалд даатгуулсан болон стандартын шаардлага хангасан

¹¹ Үндэсний их баяр наадмын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2022 оны 25 дугаарт нийтлэгдсэн.



хамгаалалтын хувцас, хэрэглэж байгаа эсэхэд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, сум, баг, дүүрэг, хорооны Засаг дарга, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан хяналт тавина.

27.8.Соёл, спортын үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, хүүхдийн эрхийг хамгаалах журмыг соёлын, биеийн тамир, спортын болон хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хамтран баталж, мөрдүүлнэ.

27.9.Соёл, спортын үйл ажиллагаан дахь хүүхэд хамгааллын бодлогыг соёлын болон биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран баталж, уг бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгуулах арга хэмжээг авна.

27.10.Хүн, хуулийн этгээд хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учирсан бол холбогдох хуульд заасан хариуцлага хүлээнэ.

28 дугаар зүйл.Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгаалал

28.1.Төрийн байгууллага, албан тушаалтан гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед хүүхэд хамгааллын үйлчилгээг хязгаарлах, зогсоох шийдвэр гаргахыг хориглоно.

28.2.Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед хүүхэд хамгааллын үйлчилгээг боломжит арга, хэлбэрээр хүргэхэд холбогдох төрийн байгууллага, албан тушаалтан туслалцаа үзүүлнэ.

28.3.Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн амь нас, аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдэд учрах сөрөг нөлөөллийг бууруулах, хүүхэд хамгааллын үйлчилгээг шуурхай үзүүлэх үйл ажиллагааг хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллага, хуулийн этгээд, сайн дурын ажилтны оролцоотойгоор зохион байгуулна.

28.4.Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэхэд тоон гарын үсэг, цахим тамга, цахим баримт бичиг, мэдээллийн систем, мэдээллийн сүлжээ ашиглаж болно.

28.5.Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед үзүүлэх хүүхэд хамгааллын үйлчилгээний стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.



28.6.Гамшиг, гамшигийн онцгой нөхцөл байдлын үед хүүхдийг насанд хүрсэн хүнд харгалзуулахгүйгээр орхих, хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахаас бусад тохиолдолд хүүхдийг байгаа газраас нь авч явах, тээвэрлэхийг хориглоно.

29 дүгээр зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгаалал

29.1.Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байгаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд долоон нас хүрсэн хүүхдийн үг хэлэх, саналаа илэрхийлэх эрхийг заавал хангана.

29.2.Хүүхдээс тайлбар, мэдүүлэг, санал авах, хүүхдийн биед үзлэг, нэгжлэг хийх ажиллагааг хүүхдийн нас, хүйс, сэтгэхүйн онцлогт тохирсон тусгай өрөөнд гүйцэтгэх бөгөөд уг ажиллагааг хүүхдийн хууль ёсны төлөөлөгчийг байлцуулахгүйгээр гүйцэтгэхийг хориглоно.

29.3.Эрх бүхий албан тушаалтан, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, шүүх хүүхдээс тайлбар, мэдүүлэг, санал авахын өмнө дараах ажиллагааг гүйцэтгэсэн байна:

29.3.1.хүүхэд өөрийн санал, шийдвэрээ гаргахад нь шаардлагатай мэдээллийг өгөх;

29.3.2.өөрийнх нь хүсэл зориг, дэмжсэн санал, хэлсэн үг, шийдвэрээс гарч болох үр дагаврыг тайлбарлах.

29.4.Эрх бүхий албан тушаалтан, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, прокурор, шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн талаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчөөр томилогдсон этгээдийн болон хүүхэд 14 нас хүрсэн бол түүний зөвшөөрөлгүйгээр олон нийтэд мэдэгдэхийг хориглоно.

29.5.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн хэрэг, маргаанд шинжээчийн дүгнэлт гаргах мэргэжилтнийг бэлтгэх, сургах, гэрчилгээжүүлэх ажлыг Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран зохион байгуулна.

29.6.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгааллын журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд, Улсын ерөнхий прокурор, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга хамтран батална.



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦОО, УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

30 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын тогтолцоо

30.1. Хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо нь хүүхэд хамгааллын байгууллага, мэргэшсэн хүний нөөц, хүүхэд хамгааллын үйлчилгээ, хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээллийн сан, хяналт-шинжилгээ, үнэлгээ, төсөв, санхүү бүхий олон талт, цогц хамтын ажиллагаанаас бүрдэнэ.

30.2. Хүүхэд хамгааллын талаар Монгол Улсын хууль тогтоомжид тусгайлан заасан тохиолдолд тухайн үйлчилгээ, үйл ажиллагаа, арга хэмжээ нь хүүхэд хамгааллын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болно.

30.3. Төрийн байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хүүхэд хамгааллыг дэмжих, хэрэгжүүлэх үүрэгтэй.

30.4. Ажил олгогч, хуулийн этгээд дотооддоо хэрэгжүүлэх байгууллагын хүүхэд хамгааллын бодлогыг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

30.5. Хүүхдийн эсрэг болон хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэж эрүүгийн хариуцлага хүлээсэн хүнийг хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг байгууллагад ажиллуулах, хүүхэдтэй холбоотой ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.

Тайлбар: Энэ хуульд заасан “хүүхэд хамгааллын бодлого” гэж хүүхдийг эрсдэлт нөхцөлд орох, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин бүрдүүлэх зорилго, зорилт, ажилтны мөрдөх ёс зүйн хэмжээг тодорхойлсон тухайн байгууллага, хуулийн этгээдээс баталсан баримт бичгийг ойлгоно.

31 дүгээр зүйл. Хүүхэд хамгааллын удирдлага, зохион байгуулалт

31.1. Хүүхэд хамгааллын удирдлага, зохион байгуулалт нь Засгийн газар, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, сум, хорооны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл, нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны Засаг дарга, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хамтарсан багаас бүрдэнэ.

31.2.Монгол Улсад хүүхдийг хамгаалах үйл ажиллагаанд хүн, хуулийн этгээдийг энэ хуульд заасны дагуу оролцуулж болно.

32 дугаар зүйл.Засгийн газрын чиг үүрэг

32.1.Засгийн газар хүүхэд хамгааллын хууль тогтоомжийн биелэлтийг хангах, Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт хүүхдийн эрх, хүүхдийн сайн сайхан байдлыг хангах талаар хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээг тусгах, хүүхэд хамгааллыг тогтвортой санхүүжилтээр хангах үүрэгтэй.

33 дугаар зүйл.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг

33.1.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүүхэд хамгааллын асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

33.1.1.хүүхэд хамгааллын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

33.1.2.хүүхэд хамгааллын чиглэлээр олон улсын болон гадаад улсын байгууллагатай хамтран ажиллах;

33.1.3.хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдэд тавигдах шаардлага, магадлан итгэмжлэх журмыг батлах;

33.1.4.хуульд заасан бусад чиг үүрэг.

34 дүгээр зүйл.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

34.1.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүүхэд хамгааллын асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

34.1.1.хүүхэд хамгааллын талаар гүйцэтгэсэн ажлын үр дүнг Засгийн газар, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын өмнө жил бүр хариуцан тайлагнах;

34.1.2.хүүхэд хамгааллын хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх арга хэмжээг авах, мэдээлэл, хяналт-шинжилгээ,



үнэлгээний үндсэн дээр тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах;

34.1.3.хүүхэд хамгааллын үйлчилгээний төсөв, санхүүжилтийн бодлогыг хэрэгжүүлэх, зарцуулалтад хяналт тавих;

34.1.4.хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хамтарсан баг, хүүхэд харагч, өдөр өнжүүлэх төв, хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;

34.1.5.хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн сан, хүүхэд хамгааллын цахим хувийн хэргийн санг хөгжүүлэх, ашиглах;

34.1.6.хууль сахиулах байгууллага, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн талаар мэдээллийн сан бүрдүүлж, хөгжүүлэх;

34.1.7.хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, үнэлэх, дүгнэх;

34.1.8.хүүхэд хамгааллын тогтолцоонд оролцогч талуудын салбар дундын хамтын ажиллагааг удирдан зохион байгуулах, уялдааг хангах;

34.1.9.хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх ажилтныг давтан сургах, мэргэшүүлэх ажлыг холбогдох байгууллага, их, дээд сургуультай хамтран зохион байгуулах;

34.1.10.хуулийн этгээд, төрийн байгууллага, шүүх, прокурор, хууль сахиулах байгууллагын алба хаагч, ажилтныг хүүхэд хамгааллын чиглэлээр сургаж, мэргэшүүлэх талаар тухайн байгууллагатай хамтран ажиллах;

34.1.11.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй харилцах талаар хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, хууль сахиулах байгууллагын алба хаагчийг давтан сургах, мэргэшүүлэх ажлыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулах;



34.1.12.хуулийн этгээд хүүхэд хамгааллын бодлого баталж, хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

34.1.13.хүүхэд хамгааллын талаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил зохион байгуулах;

34.1.14.хүүхэд хамгаалалд хүн, хуулийн этгээд, гэр бүл, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг дэмжих;

34.1.15.барилга байгууламж, авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд хүүхдийн эрхийн улсын байцаагч, эсхүл хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээдийн төлөөллийг оруулах асуудлыг эрх бүхий этгээдэд тавьж шийдвэрлүүлэх;

34.1.16.хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх ажилтныг давтан сургах, мэргэшүүлэх хөтөлбөр, журмыг батлах;

34.1.17.хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид зориулсан сургалтын хөтөлбөр, журмыг батлах;

34.1.18.хуульд заасан бусад чиг үүрэг.

35 дугаар зүйл.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын чиг үүрэг

35.1.Аймаг, нийслэл, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхэд хамгааллын асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

35.1.1.хүүхэд хамгааллын талаарх судалгаа, тайланд үндэслэн цаашид хэрэгжүүлэх ажлын чиглэлийг эрэмбэлэн тодорхойлох;

35.1.2.хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлэх;

35.1.3.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, тандалт судалгаа явуулах, бүртгэх ажлыг орон нутгийн цагдаагийн байгууллага болон холбогдох бусад байгууллагатай хамтран зохион байгуулах;

35.1.4.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо болон хүүхэд хамгааллын үйлчилгээний талаарх дундын мэдээллийн санд үндэслэн хүүхэд хамгааллын үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлэх;



35.1.5.хамтарсан багт дэмжлэг үзүүлэх зорилгоор хүүхэд хамгааллын үйлчилгээний тодорхой чиглэл буюу нийгмийн ажлын үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх, бага насны болон хохирогч хүүхэдтэй ажиллах зэрэг мэргэшсэн дэмжих багийг байгуулах;

35.1.6.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, түүний гэр бүлд үзүүлсэн хүүхэд хамгааллын үйлчилгээний талаар нэгдсэн бүртгэл, судалгаа хөтөлж, хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээллийн санд оруулах;

35.1.7.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдэд тусламж, дэмжлэг үзүүлэх талаар хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;

35.1.8.магадлан итгэмжлэгдсэн хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулж ажиллах;

35.1.9.гэр бүл, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүүхэд өсгөн хүмүүжүүлэх, хамгаалах талаар шаардлагатай зөвлөгөө, сургалт, тусламж, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;

35.1.10.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг сайн дурын болон хуульд заасны дагуу шүүхийн шийдвэрээр албадан сургалтад хамруулах ажлыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран зохион байгуулах;

35.1.11.төрийн байгууллага, шүүх, прокурор, хууль сахиулах байгууллага, хуулийн этгээдийн ажилтан, албан хаагчийг хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр сургах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;

35.1.12.хуульд заасан бусад чиг үүрэг.

35.2.Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагыг чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь мэргэжил, арга зүйн удирдлага, дэмжлэгээр хангаж ажиллана.

35.3.Аймаг, нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын даргыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга хуульд заасны дагуу томилж, чөлөөлнө.



35.4.Дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын даргыг нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын дарга хуульд заасны дагуу томилж, чөлөөлнө.

35.5.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын дарга Төрийн албаны тухай хуульд¹² заасан нийтлэг шаардлагаас гадна хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн байгууллагад 4-өөс доошгүй жил, үүнээс хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнаар 2-оос доошгүй жил ажилласан байна.

36 дугаар зүйл.Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан

36.1.Нийгмийн ажилтны мэргэжлээр дээд боловсролтой, эсхүл боловсрол, нийгмийн ухааны чиглэлээр дээд боловсрол эзэмшиж, нийгмийн ажлаар мэргэшүүлэх сургалтад хамрагдсан хүнд нийгмийн ажлын үйлчилгээ явуулах эрх олгосны үндсэн дээр хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнаар ажиллуулна.

36.2.Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан дараах үүрэг хүлээнэ:

36.2.1.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, мэдээлэл хүлээн авах, бүртгэх, нягтлан шалгах;

36.2.2.шуурхай тусламжийн үйлчилгээний хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах;

36.2.3.эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх, дүгнэлт гаргах, эдгээрт үндэслэн хүүхэд хамгааллын үйлчилгээг төлөвлөх, хүргэх, үнэлэх, хаах, эргэн хянах;

36.2.4.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, түүний гэр бүлд хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэхэд кейс менежмент хийх;

36.2.5.хүүхэд хамгааллын кейс бүрд хүүхэд хамгааллын үйлчилгээний үйл явцыг холбогдох журам, зааврын дагуу бүртгэх, баримтжуулах, архивлах, мэдээллийн санд оруулах;

36.2.6.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, түүний гэр бүлд үзүүлсэн хүүхэд хамгааллын үйлчилгээний талаарх тайлан, мэдээллийг харьяа хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагад тухай бүр хүргүүлэх;

¹² Төрийн албаны тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2018 оны 01 дугаарт нийтлэгдсэн.



36.2.7.хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах;

36.2.8.хүүхэд гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсон байж болзошгүй нөхцөл байдлын талаар харьяа хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэх;

36.2.9.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр оролцох;

36.2.10.нийгмийн ажлын үйлчилгээний стандартыг дагаж мөрдөх.

36.3.Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан дараах эрх эдэлнэ:

36.3.1.хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулсан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн талаар, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хүүхдийг төлөөлөн холбогдох байгууллагад өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх;

36.3.2.хүүхэд хамгааллын асуудлаар хүүхэд, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүн, хуулийн этгээд, олон нийтэд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх, сургалт, зөвлөгөө өгөх, шаардлага тавих;

36.3.3.мэргэжлийн ёс зүй, энэ хуульд заасан үүрэг болон үйлчлүүлэгчид харш үйлдэл гүйцэтгэхээс татгалзах;

36.3.4.хүүхэд хамгааллын үйлчилгээтэй холбоотой мэдээ, мэдээлэл, баримт бичгийг холбогдох этгээдээс үнэ төлбөргүй гаргуулан авах;

36.3.5.хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхэд өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учрах нөхцөл үүсэхээр бол хууль сахиулагчийн туслалцааг авах.

36.4.Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ёс зүйн дүрэмтэй байх бөгөөд уг дүрмийг мэргэжлийн холбоодтой зөвшилцөн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.



36.5.Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд нийгмийн ажлын үйлчилгээ явуулах эрх, мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

36.6.Тухайн нэгжийн нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, гэр бүл, хүүхдийн тоо, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн гаралт зэргийг үндэслэн сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлалыг Засгийн газар батална.

36.7.Сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн санал болгосноор Засгийн газар батална.

36.8.Сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын дарга хуульд заасны дагуу томилж, чөлөөлнө.

37 дугаар зүйл.Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөлийн чиг үүрэг

37.1.Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл хүүхэд хамгааллын асуудлаар Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16.4-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

37.2.Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл жил бүрийн 3 дугаар улиралд багтаан хүүхэд хамгааллын талаар хийсэн ажлын тайланг хэлэлцэж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар холбогдох гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн байгууллагад чиглэл, нутгийн өөрөө удирдах байгууллага, холбогдох бусад хуулийн этгээдэд зөвлөмж өгч, бодлого тодорхойлох, шийдвэр гаргах эрх бүхий оролцогч талуудад санал оруулна.

38 дугаар зүйл.Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг

38.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хүүхэд хамгааллын асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

38.1.1.аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичиг, хөгжлийн жилийн төлөвлөгөө, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хүүхдийн эрх, хүүхдийн сайн сайхан байдлыг хангах үйл ажиллагаа, арга хэмжээг тусгаж, биелэлтэд нь хяналт тавих;

38.1.2.хүүхэд хамгааллын санхүүжилт, хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажил, үйлчилгээний зардлыг орон нутгийн төсөвт жил бүр тусгаж батлах;

38.1.3.жилд хоёроос доошгүй удаа тухайн шатны хүүхдийн төлөө зөвлөлийн тайлан, Засаг даргын саналыг хэлэлцэж, чиглэл өгөх;

38.1.4.хуульд заасан бусад чиг үүрэг.

39 дүгээр зүйл.Бүх шатны Засаг даргын чиг үүрэг

39.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ хүүхэд хамгааллын асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

39.1.1.хүүхэд хамгааллын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах;

39.1.2.тухайн шатны жилийн төсвийн төсөлд хүүхэд хамгааллын санхүүжилтийг тусгах;

39.1.3.хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага үйл ажиллагаагаа хэвийн явуулахад тусламж, дэмжлэг үзүүлэх;

39.1.4.хуульд заасан бусад чиг үүрэг.

39.2.Сум, дүүргийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ хүүхэд хамгааллын асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

39.2.1.хүүхэд хамгааллын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага, дээд шатны Засаг даргаас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах;

39.2.2.хүүхэд хамгааллын үйлчилгээнд хууль тогтоомж, стандартыг сахин мөрдөж байгаа эсэхэд харьяалал, өмчийн хэлбэрийг харгалзахгүйгээр хяналт тавих;

39.2.3.тухайн нутаг дэвсгэрийн онцлог, төвөөс алслагдсан байдлыг харгалзан хүүхэд хамгааллын үйлчилгээг явуулын хэлбэрээр үзүүлэх ажлыг зохион байгуулах;

39.2.4.хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг ажиллах нөхцөл, боломжоор хангах;

39.2.5.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20.1-д зааснаар хамтарсан багийг ахлах;

39.2.6.хуульд заасан бусад чиг үүрэг.

39.3.Баг, хорооны Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ хүүхэд хамгааллын асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

39.3.1.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, бүртгэх ажлыг хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтантай хамтран хэрэгжүүлэх;

39.3.2.хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдалд тандалт судалгаа хийж, шаардлагатай асуудлыг дээд шатны Засаг дарга, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

39.3.3.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20.1 дэх хэсэгт зааснаар хамтарсан багийг ахлах;

39.3.4.хуульд заасан бусад чиг үүрэг.

Нэгдүгээр дэд бүлэг

Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хамтарсан баг

40 дүгээр зүйл.Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо

40.1.Аймаг, дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий хүүхдийн эрхийн хууль зүйн хороо /цаашид “хууль зүйн хороо” гэх/-г тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай зөвшилцөн байгуулна.

40.2.Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн дараах байгууллагын удирдах албан тушаалтнаас бүрдэнэ:

40.2.1.нутгийн өөрөө удирдах байгууллагын ажлын алба;

40.2.2.аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар, хэлтэс;

40.2.3.аймаг, дүүргийн боловсролын газар, хэлтэс;

40.2.4.аймгийн эрүүл мэндийн газар, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв;



40.2.5.аймаг, дүүргийн хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний газар, хэлтэс;

40.2.6.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын алба;

40.2.7.Засаг даргын ажлын албаны хуулийн асуудал хариуцсан нэгж;

40.2.8.аймаг, дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтэс;

40.2.9.аймаг, нийслэл, дүүрэг дэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс;

40.2.10.аймаг, дүүргийн прокурорын газар;

40.2.11.шүүхийн тамгын газар.

40.3.Хууль зүйн хорооны бүрэлдэхүүнд хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хүн, хуулийн этгээд, хуульч, өмгөөлөгчдийн мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагын тухайн орон нутаг дахь салбар, нэгжийн төлөөллийг оруулж болно.

40.4.Хууль зүйн хороог шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэгж, сум буюу сум дундын прокурорын газар болон шүүх ажиллаж байгаа сумдад аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвшөөрснөөр сумын Засаг дарга тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай зөвшилцөн байгуулна.

40.5.Энэ хуулийн 40.2-т заасан нэгж суманд байхгүй бол тухайн асуудлыг хариуцсан албан хаагчийг хууль зүйн хорооны бүрэлдэхүүнд оруулна.

40.6.Хууль зүйн хорооны даргын үүргийг Засаг дарга, эсхүл түүний даалгаснаар Засаг даргын орлогч, эсхүл тухайн аймаг, дүүргийн Засаг даргын ажлын албаны хуулийн асуудал хариуцсан нэгжийн дарга тус тус гүйцэтгэнэ.

40.7.Хууль зүйн хорооны гишүүн өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хууль зүйн хороо, түүний ажлын албыг мэдээллээр хангах, хууль зүйн хорооноос гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг харьяа байгууллагын хэмжээнд хариуцан гүйцэтгэх үүрэгтэй.

40.8.Хууль зүйн хорооны гишүүн хууль зүйн хороонд хандсан, үйлчилгээ авсан хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгчийн талаарх хүний хувийн болон эмзэг мэдээллийг задруулахгүй байх үүрэгтэй.



40.9.Хууль зүйн хороо ажлын албатай байх бөгөөд уг ажлын албаны чиг үүргийг аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага, сум дахь хууль зүйн хорооны нарийн бичгийн даргын үүргийг тухайн сумын хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан гүйцэтгэнэ.

41 дүгээр зүйл.Хууль зүйн хорооны чиг үүрэг

41.1.Хууль зүйн хороо хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдэд дараах үйлчилгээг үзүүлэхээр шийдвэр гаргаж, биелэлтийг хангаж ажиллана:

41.1.1.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдэд үзүүлэх үйлчилгээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

41.1.2.шаардлагатай тохиолдолд бага насны хүүхдийн мэдүүлгийг дуу, дуу-дүрсний бичлэгээр урьдчилан баталгаажуулж авах ажлыг зохион байгуулах;

41.1.3.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхэд эцэг, эх, гэр бүлийн гишүүд болон бусад этгээдийн дарамт, шахалтад өртөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө, эрх зүйн туслалцаа, мэдээлэл өгөх, хүүхэд өөрөө бие даан шийдвэр гаргах, саналаа хэлэх, хүсэлт гаргах нөхцөлийг хангах;

41.1.4.эцэг, эх, гэр бүлийн гишүүд, үе тэнгийнхэн, сургууль, хамт олонд зөвлөгөө өгөх, уулзалт, ярилцлага зохион байгуулж, үр дүнг тооцох;

41.1.5.хүүхдийг хорт зуршлаас ангижрах эмчилгээ, зан үйлд нөлөөлөх сургалтад хамруулах;

41.1.6.өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, зөрчилд холбогдогчийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үеэр түүнд учирч болох сөрөг нөлөөллөөс сэргийлэх зорилгоор мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, эрх бүхий албан тушаалтантай хамтран ажиллах, хүүхдэд батлан даагч томилуулахаар санал гаргах;

41.1.7.гэмт хэрэг, зөрчлийн хохирогч, гэрч хүүхэд болон цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авснаас бусад тохиолдолд өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, холбогдогчоос тайлбар, мэдүүлэг авах ажиллагааг хүүхдийн байгаа газар, тусгай өрөөнд зохион байгуулах арга хэмжээг авах;

41.1.8.хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдэд олгох сургалт, хүмүүжлийн хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

41.1.9.хорих ялаар шийтгүүлсэн хүүхдийг сурч боловсрох эрхээ эдлэхэд шаардлагатай орчин, нөхцөлөөр хангах ажлыг зохион байгуулах;

41.1.10.хорих ялаар шийтгүүлсэн хүүхдийг хугацаанаас өмнө нь суллуулах асуудлаар хорих байгууллага, прокурорт санал гаргах, хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан хүүхдэд хяналтын хугацаанд үүрэг хүлээлгэсэн тохиолдолд уг үүргийг биелүүлэхэд зөвлөгөө өгөх, дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

41.1.11.тогтоолын биелэлтийг хойшлуулсан, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдэд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг биелүүлэхэд зөвлөгөө өгөх, дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

41.1.12.хорих ял, баривчлах шийтгэлээр шийтгүүлсэн, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан, эцэг, эх, харгалзан дэмжигчгүй хүүхдийг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага, баривчлах байр, цагдан хорих төвөөс суллагдсан үед хүлээн авч, хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамруулж, зохих байгууллагад шилжүүлэх;

41.1.13.өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, зөрчилд холбогдогч, эрүүгийн хариуцлага, зөрчлийн шийтгэл хүлээсэн хүүхдийг хөгжүүлэх сургалт, хөтөлбөрт хамруулах;

41.1.14.сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхэд, түүний эцэг, эх, харгалзан дэмжигчийг ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамруулах;

41.1.15.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн¹³ үйлчлэлд хамаарахгүй хүүхдэд хууль зүйн болон хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах.

41.2.Хууль зүйн хороо үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэхэд гарах зардлын төсвийг боловсруулж, тухайн шатны хүүхдийн төлөө зөвлөлөөр батлуулна.

41.3.Хууль зүйн хорооны шийдвэр, үзүүлсэн үйлчилгээний мэдээллийн санг бүрдүүлэх үүргийг ажлын алба хэрэгжүүлж, хүүхэд, гэр

¹³ Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2013 оны 30 дугаарт нийтлэгдсэн.



бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавина.

42 дугаар зүйл.Хууль зүйн хорооны хуралдаан, түүнээс гарах шийдвэр

42.1.Хууль зүйн хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр хуралдаан байх бөгөөд хуралдаанаас гарах шийдвэр нь тогтоол, зөвлөмж хэлбэртэй байна.

42.2.Хууль зүйн хорооны хуралдааныг гишүүдийн олонх оролцсоноор хүчинтэйд тооцох бөгөөд асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

42.3.Хууль зүйн хорооны хуралдааныг энэ хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн мэдээллийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор, шаардлагатай тохиолдолд дарга, эсхүл хоёр буюу түүнээс дээш гишүүний санаачилгаар хийнэ.

42.4.Ажлын алба хууль зүйн хорооны хуралдаан болохоос ажлын хоёроос доошгүй өдрийн өмнө хуралдаанаар хэлэлцэх асуудлын талаарх мэдээлэл, холбогдох баримт бичгийг гишүүдэд тараасан байна.

42.5.Хууль зүйн хороо хуралдааны дэгийг өөрөө тогтооно.

42.6.Хууль зүйн хороо хэвлэмэл хуудастай байна. Хууль зүйн хорооны шийдвэрт тухайн орон нутгийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын тэмдгийг хэрэглэнэ.

42.7.Хууль зүйн хорооны шийдвэрийг хэрэгжүүлээгүй, эсхүл хэрэгжүүлэхэд саад учруулсан төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах саналыг хууль зүйн хороо эрх бүхий этгээдэд хүргүүлж болно.

43 дугаар зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн талаар хууль зүйн хороонд мэдэгдэх үүрэг

43.1.Дараах этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн мэдээллийг харьяа хууль зүйн хорооны ажлын албанд хүргүүлнэ:

43.1.1.эрх бүхий албан тушаалтан, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага өсвөр насны сэжигтэн, яллагдагч, зөрчилд

холбогдогч, гэмт хэрэг, зөрчлийн хохирогч, гэрч хүүхдийн мэдээллийг тухай бүр;

43.1.2.шүүх шүүхэд шилжүүлсэн өсвөр насны яллагдагч, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан, ял шийтгэгдсэн, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан, иргэний болон захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа хүүхдийн мэдээллийг тухай бүр;

43.1.3.шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж байгаа хүүхдийн мэдээллийг ялын хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө, бусад үндэслэлээр суллагдсан тохиолдолд суллагдсанаас хойш 3 хоногийн дотор.

43.2.Хууль зүйн хорооны ажлын алба энэ хуулийн 43.1-д заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн мэдээллийг хүлээн авсан, эсхүл өөрөө олж авсан тохиолдолд хууль зүйн хороогоор зохих шийдвэрийг гаргуулж, хүүхдэд шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэх ажлыг зохион байгуулна.

43.3.Хууль зүйн хорооны ажлын алба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээг кейс менежментийн үе шатны хүрээнд үзүүлнэ.

43.4.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхэд, түүний гэр бүлд хийсэн нөхцөл байдлын үнэлгээний тайланг эрх бүхий этгээдэд хүргүүлэх бөгөөд эрх бүхий этгээд нөхцөл байдлын үнэлгээний тайланг хэргийн материалд хавсаргаж, нотлох баримтаар үнэлэх эрхтэй.

43.5.Эрх бүхий албан тушаалтан, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэхэд харьяа хууль зүйн хороо, түүний ажлын албатай тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусах хүртэл хугацаанд хамтран ажиллана.

44 дүгээр зүйл.Хамтарсан баг

44.1.Хамтарсан баг хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхдээ хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, сум, хорооны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтантай хамтран ажиллана.

44.2.Хамтарсан багийн гишүүд хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэхэд өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд туслах үүрэгтэй.

44.3.Хамтарсан багийн гишүүн болон хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх явцад хамтарсан багтай хамтран ажиллаж байгаа хүн, хуулийн этгээд хүүхдийн мэдээллийг нууцлах үүрэгтэй бөгөөд тэднээс нууц хамгаалах баталгааг бичгээр авна.

45 дугаар зүйл.Хамтарсан багийн чиг үүрэг

45.1.Хамтарсан баг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд зааснаас гадна харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхэд хамгааллын асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

45.1.1.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэх;

45.1.2.хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох, хүүхэд аюултай нөхцөл байдалд орсон бол шуурхай тусламжийн үйлчилгээг үзүүлэх;

45.1.3.хүүхэд эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллага, магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээдтэй хамтран зохион байгуулах;

45.1.4.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, түүний гэр бүлд үзүүлэх хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

45.1.5.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, шаардлагатай бусад үйлчилгээнд холбон зуучлах ажлыг зохион байгуулах;

45.1.6.тухайн жилд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах төсвийн саналыг харьяа хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагад хүргүүлэх.

45.2.Хамтарсан баг хүүхэд, гэр бүлд үзүүлсэн хүүхэд хамгааллын үйлчилгээг мэдээллийн санд бүртгэж, харьяа хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагад хүргүүлнэ.

46 дугаар зүйл.Хамтарсан багийн зохион байгуулалт

46.1.Хамтарсан багийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр хуралдаан байх бөгөөд хуралдаанд хамтарсан багийн гишүүдийн олонх оролцсоноор хүчинтэйд тооцож, асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

46.2.Хамтарсан багийн нарийн бичгийн даргын үүргийг сум, хорооны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан гүйцэтгэнэ.

46.3.Хамтарсан багийн хуралдаанаас гарах шийдвэр нь дүгнэлт, тэмдэглэл хэлбэртэй байна.

47 дугаар зүйл.Хүүхэд хамгаалалд хүн, хуулийн этгээд, олон улсын байгууллагын оролцоо

47.1.Хүүхэд хамгааллын үйлчилгээг тухайн чиглэлээр мэргэшсэн хүн, магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээдээр гэрээгээр гүйцэтгүүлж болно.

47.2.Хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг хүн, хуулийн этгээдийн мэдээллийн санг хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага бүртгэж, хөтөлнө.

47.3.Хүүхэд хамгааллын үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж байгаа хүн, хуулийн этгээд мэргэжлийн ёс зүйн дүрэм, нийгмийн ажлын үйлчилгээний стандартыг мөрдөж ажиллах үүрэгтэй.

47.4.Хүүхэд хамгааллын үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж байгаа хүн, хуулийн этгээд гэрээний үүргээ удаа дараа, эсхүл ноцтой зөрчсөн, хүчирхийлэл үйлдсэнийг шүүх, хүүхдийн эрхийн улсын байцаагч, эрх бүхий албан тушаалтан тогтоосон тохиолдолд тухайн этгээдийг хүүхэд хамгааллын үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах үндэслэл болно.

47.5.Энэ хуулийн 47.4-т заасан нөхцөл үүссэн бол хүүхдийн эрхийн улсын байцаагч тухайн этгээдийг эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах саналаа холбогдох нотлох баримтын хамт хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

47.6.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 47.4-т заасан нөхцөл үүссэнийг тогтоосон тухай хүүхдийн эрхийн улсын байцаагчийн саналыг үндэслэн хүүхэд хамгааллын үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтөлж, нийтэд мэдээлнэ.

47.7.Хүн, хуулийн этгээдийг эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах хугацаа нь энэ тухай хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр гарсан өдрөөс хойш гурван жилийн хугацаанд хүчинтэй байна.

47.8.Хүн, хуулийн этгээд хүүхэд хамгааллын үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх, хандив өгөх, бусад хэлбэрээр дэмжлэг, туслалцаа үзүүлж болно.

47.9.Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын болон гадаад улсын байгууллага, магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээдээр хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаар хөндлөнгийн хяналт, шинжилгээ хийлгэж болно.

47.10.Олон улсын болон гадаад улсын байгууллага хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр Монгол Улсад хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаар тандалт судалгаа хийхийг хориглоно.

47.11.Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын болон гадаад улсын байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь Монгол Улсын хүүхэд хамгааллын бодлого, хүүхэд хамгааллын үйлчилгээний шаардлага, стандартад нийцсэн байна.

48 дугаар зүйл.Хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн сан

48.1.Хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээллийн сантай байна.

48.2.Хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн сангийн дэд бүрэлдэхүүн нь хүүхдийн цахим хувийн хэрэг байна.

48.3.Хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн сангийн хэрэг бүрдүүлэх зарчим, хэлбэр нэгдмэл байна.

48.4.Хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хадгалах, аюулгүй байдлыг хангах, ашиглах журмыг Засгийн газар батална.

ТАВДУГААР БҮЛЭГ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН МЭРГЭЖЛИЙН УДИРДЛАГА

49 дүгээр зүйл.Хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлага, түүний хэлбэр

49.1.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлагаар хангах /цаашид “мэргэжлийн удирдлага” гэх/ үүргийг хэрэгжүүлнэ.



49.2.Мэргэжлийн удирдлагыг хүүхэд хамгааллын үйлчилгээний статистик мэдээ, судалгаа, дүгнэлтэд үндэслэн нэгдсэн зохион байгуулалтын болон хүүхэд хамгааллын тодорхой кейстэй холбоотойгоор удирдан чиглүүлэх, дэмжих, зөвлөн туслах, хөгжүүлэх хэлбэрээр хэрэгжүүлнэ.

49.3.Хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлэх аргачлал, зааврыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

50 дугаар зүйл.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагаа

50.1.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүүхэд хамгааллын үйлчилгээг мэргэжлийн удирдлагаар хангах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

50.1.1.хүүхэд хамгааллын үйлчилгээний статистик мэдээ, судалгаа, дүгнэлтэд үндэслэн хүүхэд хамгааллын үйлчилгээний мэргэжлийн удирдлагын хэтийн болон ойрын зорилтыг тодорхойлох;

50.1.2.хүүхэд хамгааллын үйлчилгээнд гарч байгаа алдаа дутагдал, бэрхшээлийг тухай бүр тодорхойлж, хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор нэгдсэн зөвлөмж, аргачлал, зааврыг боловсруулж, мөрдүүлэх;

50.1.3.хүүхэд хамгааллын үйлчилгээний статистик мэдээ, хүүхэд хамгааллын кейсээс түүвэрлэн хянаж, нийтлэг гарч байгаа алдаа, дутагдлыг тогтоож, зохих чиглэл тус бүрээр сургалт зохион байгуулах;

50.1.4.хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын албан хаагч, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангаж, хэрэгжүүлсэн ажлыг шалгаж, биелэлтийг дүгнэх, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар чиглэл, зааварчилгаа өгөх;

50.1.5.хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын албан хаагч, хүүхэд, гэр бүлийн болон бусад салбарын нийгмийн ажилтантай ганцаарчилсан болон хамтарсан уулзалт, ярилцлагыг зохион байгуулж, зөвлөмж, зөвлөгөө өгөх;

50.1.6.хүүхэд, гэр бүлийн болон бусад салбарын нийгмийн ажилтныг сургах, давтан мэргэшүүлэх, ажлын байран дахь зөвлөн туслах ажлыг зохион байгуулах.

51 дүгээр зүйл.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагаа

51.1.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага хүүхэд хамгааллын үйлчилгээг мэргэжлийн удирдлагаар хангах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

51.1.1.тухайн орон нутгийн хамтарсан баг, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж байгаа этгээдийг мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах;

51.1.2.хүүхэд хамгааллын кейс бүрийн материалтай танилцаж, алдаа, дутагдлыг арилгах арга хэмжээ авах, энэ талаар илтгэх хуудаст тусгах;

51.1.3.хүүхэд хамгааллын үйлчилгээний явцад хийгдэж байгаа ажиллагаа, баримтжуулалтад хяналт тавих;

51.1.4.хүүхэд хамгааллын кейсийн статистик мэдээ, кейс шийдвэрлэлтэд үндэслэн хамтарсан баг, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж байгаа этгээдэд зохих чиглэл тус бүрээр сургалт зохион байгуулах;

51.1.5.хамтарсан баг, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж байгаа этгээдтэй ганцаарчилсан болон хамтарсан уулзалт зохион байгуулж, тулгамдсан асуудлаар ярилцлага хийх, чиглэл, зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх;

51.1.6.арав хүртэлх нийгмийн ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангах нэг ахлах нийгмийн ажилтан, тав хүртэлх ахлах нийгмийн ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангах нэг зөвлөх нийгмийн ажилтан ажиллахаар тооцож зохион байгуулалт хийх.

**ЗУРГАДУГААР БҮЛЭГ
ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН САНХҮҮЖИЛТ БА ХЯНАЛТ**

52 дугаар зүйл.Хүүхэд хамгааллын санхүүжилт

52.1.Хүүхэд хамгааллыг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

52.1.1.улсын төсөв;

52.1.2.орон нутгийн төсөв;

52.1.3.үндэсний болон олон улсын төсөл, хөтөлбөр;



52.1.4.дотоод, гадаадын хуулийн этгээд болон олон улсын байгууллага, хувь хүнээс өгсөн хандив, тусламж.

52.2.Хүүхэд хамгааллын санхүүжилтийг энэ хуульд заасан хүүхэд хамгааллын үйлчилгээний төрөл, хэлбэр тус бүрээр улс, орон нутгийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ.

52.3.Хүүхэд хамгааллын санхүүжилтийг төлөвлөхдөө өмнөх онд шийдвэрлэсэн хүүхэд хамгааллын кейсийн тоо, үйлчилгээний чанар, үр дүнд үндэслэн дараа онд олгох санхүүжилтийг тогтооно.

52.4.Төр хүүхэд хамгааллын асуудлаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар төлөөлөн гүйцэтгүүлж, чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн¹⁴ 27.2-т заасны дагуу шийдвэрлэнэ.

52.5.Хүүхэд хамгаалалд тусгасан төсвийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон орон нутгийн байгууллага, хууль зүйн хороо, хамтарсан баг болон гэрээгээр хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагаанд зарцуулна.

52.6.Засгийн газрын гишүүд эрхлэх асуудлын хүрээнд салбарын хүүхэд хамгааллын үйлчилгээ, энэ хуулийн 30.3-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгуулах арга хэмжээ авна.

52.7.Хуулийн этгээд өөрийн цалингийн нийт сангийн нэгээс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг жил бүр хүүхэд хамгааллын бодлого, Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, хүүхдэд ээлтэй, таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулахад зарцуулна.

52.8.Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний нэг хүүхдэд ногдох дундаж зардлын нормативыг Засгийн газар батална.

53 дугаар зүйл.Хүүхэд хамгааллын хяналт-шинжилгээ, үнэлгээ

53.1.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүүхэд хамгааллын нөхцөл байдлыг тодорхойлох,

¹⁴ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2021 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

Энэхүү Конвенцыг 2019 оны арван нэгдүгээр сарын хорин тавны энэ өдөр **батлав**.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

I зүйл

Энэхүү Конвенцод доорх нэр томьёог дараах утгаар ойлгоно. Үүнд:

Боломж (дээд боловсрол эзэмших) гэж шалгуур хангасан аливаа хувь хүн дээд боловсрол эзэмшихээр хүсэлт гаргах, элсэлтийн шалгалтад оролцох эрхийг,

Элсэлт (дээд боловсролын байгууллага ба хөтөлбөрийн) гэж тухайн байгууллага ба/эсхүл хөтөлбөрт дээд боловсрол эзэмших боломжийг шалгуур хангасан өргөдөл гаргагчид олгож буй үйл ажиллагаа буюу тогтолцоог,

Өргөдөл гаргагч гэж

(а) хүлээн зөвшөөрөх эрх бүхий байгууллагад өөрийн эрдмийн зэрэг, хэсэгчилсэн сургалт, эсхүл өмнөх сургалтыг үнэлүүлэх ба/эсхүл хүлээн зөвшөөрүүлэхээр өргөдөл гаргаж буй хувь хүнийг,

(b) хувь хүнээс зөвшөөрөл авсны үндсэн дээр тухайн хувь хүний нэрийн өмнөөс өргөдөл гаргаж буй байгууллагыг,

Үнэлгээ гэж эрдмийн зэргийн үнэлгээний үйл явцад оролцдог хүлээн зөвшөөрөх эрх бүхий байгууллагаас өргөдөл гаргагчийн эрдмийн зэрэг, хэсэгчилсэн сургалт, өмнөх сургалтыг үнэлсэн үнэлгээг,

Эрх бүхий байгууллага гэж тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх эрх мэдэл, чадавх, эрх зүйн чадамжтай хувь хүн, эсхүл байгууллагыг,

Хүлээн зөвшөөрөх эрх бүхий байгууллага гэж Оролцогч улсын хууль, дүрэм журам, бодлого, эсхүл тогтсон дадлын дагуу эрдмийн зэргийг үнэлэх, эсхүл хүлээн зөвшөөрөх талаар шийдвэр гаргах байгууллагыг,

Засаг захиргааны нэгж гэж энэхүү Конвенцын XX зүйлийн (b) хэсгийн дагуу холбооны эсхүл нэгдмэл бус Үндсэн хуулийн тогтолцоо ёсоор Конвенцын Оролцогч улсын аймаг, муж, тойрог, дүүрэг зэрэг орон нутгийн засаг захиргааны түвшин дэх албан ёсны байгууллагыг,

Хил дамнасан боловсрол гэж иргэд, мэдлэг, хөтөлбөр, боловсролын байгууллага, сургалтын хөтөлбөрийн Оролцогч улсуудын хил дамнасан хөдөлгөөнийг хамарсан боловсрол олгох бүхий л хэлбэрийг хэлэх бөгөөд үүнд олон улсын хамтарсан зэрэг олгох чанарын баталгаа бүхий хөтөлбөр, хил дамнасан дээд боловсрол, үндэстэн дамнасан боловсрол, оффшор боловсрол, хил хязгааргүй боловсролыг оруулах боловч эдгээрээр хязгаарлахгүй,

Шилжин суурьшсан этгээд гэж оршин суудаг орон нутаг, орчин, ажил мэргэжлийн үйл ажиллагаанаасаа аргагүй нөхцөл байдлын улмаас өөр нутаг орон, орчинд шилжин суурьшсан хувь хүнийг,

Албан боловсролын тогтолцоо гэж Оролцогч улсын боловсролын тогтолцоог, түүний дотор боловсрол олгох үүрэг бүхий албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн бүх байгууллага, түүнчлэн Оролцогч улсын эрх бүхий байгууллагуудаас сургалт болон боловсролтой холбоотой бусад үйлчилгээг үзүүлэхээр хүлээн зөвшөөрөгдөж, эрх олгогдсон төрийн болон хувийн хэвшлийн боловсролын бүх түвшний байгууллагыг,

Албан сургалт гэж зохион байгуулалттай сургалтын тогтолцоогоор албан ёсны зэрэг олгоход чиглэсэн үйл ажиллагааны дагуу хэрэгждэг, сургалтын үйл ажиллагааг явуулахаар Оролцогч улсын эрх бүхий байгууллагаас хүлээн зөвшөөрөгдөж, түүгээр эрх олгогдсон боловсролын байгууллагаас олгох сургалтыг,

Дээд боловсрол гэж Оролцогч улсын буюу түүний засаг захиргааны нэгжийн эрх бүхий байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд дээд боловсролын тогтолцоонд нь хамаарах бүрэн дунд боловсролын дараах шатны бүх төрлийн сургалтын хөтөлбөр, эсхүл багц хөтөлбөрийг,

Дээд боловсролын байгууллага гэж дээд боловсрол олгодог, Оролцогч улсын буюу түүний засаг захиргааны нэгжийн эрх бүхий байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд дээд боловсролын тогтолцоонд нь хамаарах байгууллагыг,

Дээд боловсролын хөтөлбөр гэж Оролцогч улсын буюу түүний засаг захиргааны нэгжийн эрх бүхий байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд дээд боловсролын тогтолцоонд нь хамаардаг, төгсөгчдөдөө дээд боловсролын эрдмийн зэрэг олгодог, бүрэн дунд боловсролын дараах сургалтын хөтөлбөрийг,

Албан бус сургалт гэж албан сургалтаас гадуур, ажил, гэр бүл, орчин эсхүл чөлөөт цагтай холбоотой өдөр тутмын үйл ажиллагааны үр дүнд бий болох суралцах үйл явцыг,

Олон улсын хамтарсан зэрэг гэж хил дамнасан боловсролын зэргийн төрөл бөгөөд нэгээс дээш улсад хамаарах хоёр буюу түүнээс дээш дээд боловсролын байгууллагаас олгодог нэгтгэн уялдуулсан, хамтарсан хөтөлбөрийг дүүргэснийг хүлээн зөвшөөрч болон/буюу зөвшөөрч, хамтран олгож буй эрдмийн нэг зэргийг,

Сургалтын үр дүн гэж суралцагчийн суралцах үйл явцыг дуусгасны эцэст олж авсан мэдлэг, чадварыг,

Насан туршийн сургалт гэж амьдралын мөчлөгийг бүхэлд нь хамарсан, хувь хүний чадавх, мэдлэг, ур чадвар, хандлага, чадамжийг сайжруулж, хөгжүүлэхэд чиглэсэн албан, албан бус бүхий л суралцах үйл ажиллагааг багтаасан үйл явцыг,

Шилжилт хөдөлгөөн гэж хувь хүмүүс эх орноосоо гадна сурах, судалгаа хийх, багшлах, эсхүл ажиллах зорилгоор биечлэн эсхүл цахимаар хийх хөдөлгөөнийг,

Албан бус сургалт гэж албан боловсролын тогтолцоонд хамаардаггүй бөгөөд ажиллаж, амьдрахад анхаардаг боловсрол, сургалтын хүрээнд олж авах мэдлэгийг,

Сургалтын уламжлалт бус арга гэж боловсролын хөтөлбөр болон сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ сурган хүмүүжүүлэгч болон суралцагсдыг нүүр тулан харилцахад голлон анхаарал хандуулдаггүй албан, албан бус, эсхүл албан бус сургалтын арга ажиллагааг,

Хэсэгчлэн хүлээн зөвшөөрөх гэж бүрэн гүйцэд дүүргэсэн эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх эрх бүхий байгууллагаас үлэмж ялгаатай гэдэг үндэслэлээр бүрэн хүлээн зөвшөөрөх боломжгүй нөхцөлд хэсэгчлэн хүлээн зөвшөөрөхийг,

Хэсэгчилсэн сургалт гэж бүрэн хэмжээний хөтөлбөр биш хэдий ч үлэмж мэдлэг, чадвар, хандлага, чадамж олгож чадахуйц, үнэлгээнд хамрагдсан дээд боловсролын хөтөлбөрийн аль нэг хэсгийг,

Өмнөх сургалт гэж хувь хүний албан, албан бус, эсхүл албан бус сургалтын үр дүнд олж авсан, тухайн сургалтын үр дүн, зорилго эсхүл стандартын хувьд үнэлж дүгнэсэн туршлага, мэдлэг, ур чадвар, хандлага, чадамжийг,

Эрдмийн зэрэг:

(а) **Дээд боловсролын эрдмийн зэрэг** гэж дээд боловсролын хөтөлбөрийг амжилттай дүүргэснийг гэрчилсэн, эсхүл өмнөх сургалтыг баталгаажуулсан (аль холбогдох) эрх бүхий байгууллагаас олгосон аливаа зэрэг, диплом, гэрчилгээ, эсхүл шийдвэрийг,

(б) **Дээд боловсрол эзэмших эрх олгох эрдмийн зэрэг** гэж боловсролын хөтөлбөрийг амжилттай дүүргэснийг гэрчилсэн, эсхүл өмнөх сургалтыг баталгаажуулсан (аль холбогдох), тухайн зэргийг эзэмшигч этгээдэд дээд боловсролын байгууллагын элсэлтийн шалгалтад орох эрх олгож байгаа эрх бүхий байгууллагаас олгосон аливаа зэрэг, диплом, гэрчилгээ, эсхүл шийдвэрийг,

Шаардлага хангасан өргөдөл гаргагч гэж холбогдох шалгуурыг хангаж, дээд боловсролын сургалтын элсэлтийн шалгалтад оролцох эрхтэй гэж тооцогдсон хувь хүнийг,



Эрдмийн зэргийн хүрээ гэж тогтоосон шалгуурын дагуу чанарын баталгаа бүхий эрдмийн зэрэг/мэргэжлийн ангилал, нийтлэл, зохион байгуулалтын тогтолцоог,

Чанарын баталгаажуулалт гэж боловсролын хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг тасралтгүй мөрдөж, сайжруулж байгаагаа холбогдох талуудад баталгаажуулах зорилгоор дээд боловсролын тогтолцоо, байгууллага, эсхүл хөтөлбөрийн чанарт эрх бүхий байгууллагаас үнэлгээ хийх тасралтгүй үйл явцыг,

Хүлээн зөвшөөрөх гэж өргөдөл гаргагчийн гадаад улсад эзэмшсэн боловсролын эрдмийн зэрэг, хэсэгчилсэн сургалт, өмнөх сургалтын хүчин төгөлдөр байдал болон эрдмийн түвшнийг эрх бүхий байгууллагаас дараах зорилгоор (гэхдээ эдгээрээр хязгаарлахгүй) албан ёсоор хүлээн зөвшөөрөхийг:

(a) дээд боловсролын элсэлтийн шалгалтад орох эрх олгох; ба/эсхүл

(b) ажил хөдөлмөрийн боломжийг эрэлхийлэх бололцоо олгох,

Бүс нутаг гэж ЮНЕСКО-ийн үйл ажиллагааг бүс нутгийн түвшинд хэрэгжүүлэх зорилгоор ЮНЕСКО-ийн бүс нутгийн тодорхойлолтын дагуу тогтоосон, тухайлбал, Африк, Арабын улсууд, Ази болон Номхон далай, Европ, Латин Америк ба Карибын аль нэг бүсийг,

Хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенц гэж ЮНЕСКО-ийн бүс нутаг тус бүрд дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай ЮНЕСКО-ийн конвенцууд, түүний дотор Газрын дундад тэнгисээр хиллэдэг Араб болон Европын улсуудад дээд боловсролын сургалт, диплом, эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай конвенцыг,

Тавигдах шаардлага:

(a) **Ерөнхий шаардлага** гэж дээд боловсролын тодорхой хөтөлбөр эсхүл түүний аль нэг түвшинд элсэх, эсхүл дээд боловсролын эрдмийн зэргийг тухайн түвшинд авахын тулд хангавал зохих болзол нөхцөлийг,

(b) **Тусгай шаардлага** гэж ерөнхий шаардлагаас гадна дээд боловсролын тодорхой хөтөлбөрт элсэх, эсхүл тодорхой салбарт дээд боловсролын тусгайлсан эрдмийн зэрэг авахад хангавал зохих болзол нөхцөлийг,

Үлэмж ялгаа гэж өргөдөл гаргагч хүссэн үйл ажиллагаа явуулах, тухайлбал, үргэлжлүүлэн суралцах, судалгаа хийх, хөдөлмөр эрхлэх (гэхдээ эдгээрээр



хязгаарлахгүй)-д саад болж болзошгүй гадаад улсын эрдмийн зэрэг болон тухайн Оролцогч улсын эрдмийн зэрэг хоорондын томоохон ялгааг тус тус хэлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. КОНВЕНЦЫН ЗОРИЛГО

II зүйл

Хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенцуудад тулгуурлан, тэдгээрийн уялдаа холбоо, нэмэлт өөрчлөлт, ололт амжилтыг бэхжүүлэх үүднээс энэхүү Конвенц нь дараах зорилготой байна. Үүнд:

1. Дээд боловсролын чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжиж, бэхжүүлэх;
2. Дээд боловсролын чиглэлээрх олон улсын хамтын ажиллагааны зорилгоор бүс нутаг хоорондын санал санаачилга, бодлого, инновацыг дэмжих;
3. Энэхүү Конвенцын Оролцогч улсуудын дээд боловсролын тогтолцооны ялгаатай байдлыг ойлгож, хүндлэхийн зэрэгцээ Оролцогч улсуудын дээд боловсролын эрдмийн зэрэг эзэмшигчид, дээд боловсролын байгууллагууд, ажил олгогчид, бусад оролцогч талд харилцан ашигтай байлгах үүднээс дэлхий дахинд дээд боловсролын салбар дахь шилжилт хөдөлгөөн болон ололт амжилтыг хөнгөвчлөн дэмжих;
4. Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг шударга, ил тод, тууштай, уялдаатай, цаг үеэ олсон, найдвартайгаар хүлээн зөвшөөрөх зорилгоор дэлхий нийтийг хамарсан хүртээмжтэй тогтолцоог бий болгох;
5. Дээд боловсролын байгууллага болон тогтолцооны бие даасан бөгөөд ялгаатай байдлыг хүндэтгэж, дэмжиж, хамгаалах;
6. Шударга байдал, ёс зүйн хэм хэмжээг *inter alia* хөхиүлэн дэмжих замаар эрдмийн зэргийн чанар, найдвартай байдалд итгэх итгэл, үнэмшлийг дээшлүүлэх;
7. Олон улсын шилжилт хөдөлгөөнийг дэмжих зорилгоор эрдмийн зэргийн хүрээнд болон эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөхөд дээд боловсролын байгууллага, тогтолцоонд чанарын баталгаажуулалтын соёлыг хөхиүлэн дэмжиж, чанарын баталгаажуулалт найдвартай, уялдаа холбоотой, харилцан нөхөхүйц байхад шаардлагатай чадавхыг хөгжүүлэх;
8. Холбогдох тал, Оролцогч улсууд, бүс нутгийн хооронд хүртээмжтэй, орчин үеийн, найдвартай, ил тод, холбогдол бүхий мэдээлэл боловсруулах, цуглуулах, солилцох, мөн шилдэг туршлагыг түгээх үйл явцыг хөхиүлэн дэмжих;



9. Чанартай дээд боловсролыг тэгш, хүртээмжтэй эзэмших боломжийг эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх замаар хөхиүлэн дэмжих, дүрвэгсэд ба шилжин суурьшсан этгээдийг оролцуулан бүх хүнд насан туршийн сургалтын боломжийг бүрдүүлэн дэмжих;

10. Тогтвортой хөгжлийн төлөө боловсролыг дэмжих үүднээс хүний нөөц болон боловсролын нөөцийг оновчтой ашиглахыг дэлхий даяар хөхиүлэн дэмжиж, бүх орны зохион байгуулалтын бүтэц, эдийн засаг, технологи, соёл, ардчилал, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах зэрэг болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ДЭЭД БОЛОВСРОЛД ХАМААРАХ ЭРДМИЙН ЗЭРГИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ҮНДСЭН ЗАРЧИМ

III зүйл

Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх зорилгоор энэхүү Конвенцоор дараах зарчмыг тогтоов. Үүнд:

1. Дээд боловсрол эзэмших өргөдөл гаргах, эсхүл ажил хөдөлмөр эрхлэх зорилгоор хувь хүмүүс өөрсдийн боловсролын зэрэгт үнэлгээ хийлгэх эрхтэй.
2. Эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх үйл явц нь Оролцогч улс бүрийн дүрэм, журмын дагуу ил тод, шударга, цаг үеэ олсон, алагчлалаас ангид байхаас гадна хямд өртөгтэй байна.
3. Хүлээн зөвшөөрөх тухай шийдвэр нь итгэлцэл, тодорхой шалгуур болон шударга, ил тод, алагчлалаас ангид журамд үндэслэсэн бөгөөд дээд боловсролын тэгш хүртээмжтэй байдал бол хөдөлмөр эрхлэх боломжийг нээсэн нийтийн сайн сайхны төлөө үйл хэрэг мөн болохын чухлыг онцолно.
4. Хүлээн зөвшөөрөх тухай шийдвэр нь дээд боловсролын тогтолцоо, байгууллага, хөтөлбөр, чанарын баталгаа олгох механизмын талаарх зохистой, найдвартай, хүртээмжтэй, орчин үеийн мэдээлэлд үндэслэх бөгөөд эдгээр мэдээллийг Оролцогч улсуудын эрх бүхий байгууллага, үндэсний албан ёсны мэдээллийн төв, эсхүл тэдгээртэй ижил төстэй байгууллагаас хүлээн авсан байна.
5. Хүлээн зөвшөөрөх тухай шийдвэрийг дэлхий дахины дээд боловсролын тогтолцооны ялгаатай байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр гаргасан байвал зохино.
6. Хүлээн зөвшөөрөх үнэлгээ хийх эрх бүхий байгууллага шийдвэрийг чин шударгаар гаргаж, шийдвэрийнхээ үндэслэлийг тодорхой тайлбарлах бөгөөд уг шийдвэрт гомдол гаргах журмыг тогтоосон байна.



7. Эрдмийн зэргээ хүлээн зөвшөөрүүлэхээр өргөдөл гаргагч нь эзэмшсэн эрдмийн зэргийнхээ талаар зохих ёсны, үнэн зөв мэдээлэл, бичиг баримтыг шударгаар бүрдүүлж өгөх бөгөөд холбогдох шийдвэрийн талаар гомдол гаргах эрхтэй байна.

8. Оролцогч улсуудын хооронд орчин үеийн технологи болон мэдээлэл солилцох сүлжээг ашиглахыг урамшуулан дэмжих замаар Оролцогч улсууд дээд боловсролын эрдмийн зэрэгтэй холбоотой бүх хэлбэрийн хууран мэхлэх үйлдлийг устгах арга хэмжээ авах үүрэг хүлээнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. КОНВЕНЦЫН ОРОЛЦОГЧ УЛСЫН ҮҮРЭГ

Энэхүү Конвенцоор Оролцогч улсууд дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

IV зүйл. Дээд боловсрол эзэмших боломж олгох эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх

1. Тухайн эрдмийн зэргийг олгосон Оролцогч улсын дээд боловсрол эзэмших эрх олгох ерөнхий шаардлага болон уг эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт хүлээж авсан Оролцогч улсын ерөнхий шаардлагын хооронд үлэмж ялгаа байхгүй тохиолдолд эдгээр Оролцогч улсын дээд боловсрол эзэмших эрх олгох ерөнхий шаардлагыг хангасны үндсэн дээр Оролцогч улс бүр өөрийн улсын дээд боловсролын тогтолцоонд хамруулах зорилгоор бусад Оролцогч улсад эзэмшсэн эрдмийн зэрэг болон баримтжуулсан эсхүл гэрчлүүлсэн өмнөх сургалтыг хүлээн зөвшөөрнө. Аль эсхүл, нэг Оролцогч улсад эрдмийн зэрэг олж авсан нь нөгөө Оролцогч улсад тухайн эрдмийн зэргийн үнэлгээ хийлгэхэд хангалттай.

2. Хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын уламжлалт бус аргаар олж авсан эрдмийн зэргийг чанарын баталгаажуулалтын харьцуулах боломжтой механизмд хамруулах бол тухайн Оролцогч улс буюу түүний засаг захиргааны нэгжийн дүрэм, журмын дагуу үнэлгээ хийх бөгөөд үнэлгээнд сургалтын уламжлалт аргаар олж авсан ижил төстэй эрдмийн зэрэгт хэрэглэдэг шалгуурыг ашиглана.

3. Тухайн эрдмийн зэрэг нь эрдмийн зэрэг олгосон Оролцогч улсын дээд боловсролын зөвхөн тодорхой төрлийн байгууллага эсхүл хөтөлбөрт хамрагдах боломж олгож буй бол Оролцогч улс бүр үлэмж ялгаа байхгүй бөгөөд боломжтой нөхцөлд өөрийн дээд боловсролын тогтолцоо дахь ижил төрлийн дээд боловсролын байгууллагад суралцах эсхүл хөтөлбөрт хамрагдах боломжийг тухайн эрдмийн зэрэг эзэмшигчид олгоно.

V зүйл. Дээд боловсролын эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх

1. Хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт гаргасан эрдмийн зэрэг болон түүнийг хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт хүлээж авсан Оролцогч улсын ижил төрлийн



эрдмийн зэргийн хооронд үлэмж ялгаа байхгүй тохиолдолд Оролцогч улс бүр бусад Оролцогч улсад олгосон дээд боловсролын эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрнө. Аль эсхүл, нэг Оролцогч улсад дээд боловсролын эрдмийн зэрэг олж авсан нь нөгөө Оролцогч улсад тухайн эрдмийн зэргийн үнэлгээг уг эрдмийн зэргийг эзэмшигчийн хүсэлтээр хийлгэхэд хангалттай.

2. Чанарын баталгаажуулалтын харьцуулах боломжтой механизмд хамаарах бөгөөд аль нэг Оролцогч улсын дээд боловсролын тогтолцооны нэг хэсэг хэмээн тооцогдох сургалтын уламжлалт бус хүлээн зөвшөөрөгдсөн аргаар олж авсан эрдмийн зэргийн үнэлгээг тухайн хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт хүлээж авсан Оролцогч улсын буюу түүний засаг захиргааны нэгжийн дүрэм, журмын дагуу, сургалтын уламжлалт аргаар олж авсан ижил төстэй эрдмийн зэрэгт хэрэглэдэг шалгуурыг ашиглан хийнэ.

3. Олон улсын хамтарсан эрдмийн зэрэг олгодог хил дамнасан боловсролын хүрээнд олж авсан, эсхүл наад зах нь нэг улс нь энэхүү Конвенцын Оролцогч улс болох нэгээс дээш улсад хэрэгжүүлсэн хамтарсан аливаа бусад хөтөлбөрийн хүрээнд олж авсан дээд боловсролын эрдмийн зэргийн үнэлгээг тухайн хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт хүлээж авсан Оролцогч улсын буюу түүний засаг захиргааны нэгжийн дүрэм, журмын дагуу, нэг улсад хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хүрээнд олж авсан эрдмийн зэрэгт хэрэглэдэг шалгуурыг ашиглан хийнэ.

4. Өөр Оролцогч улсад олгосон дээд боловсролын эрдмийн зэргийг аливаа Оролцогч улс хүлээн зөвшөөрснөөр доор дурдсан үр дүнгийн наад зах нь нэг нь гарна. Үүнд:

(a) тухайн эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт хүлээж авсан Оролцогч улсад дээд боловсролын эрдмийн зэрэг эзэмшигчдэдээ олгодогтой адил нөхцөлөөр дээд боловсролоо үргэлжлүүлэхээр элсэлтийн шалгалт өгөх эрхийг уг эрдмийн зэргийг эзэмшигчид олгоно; болон/эсхүл

(b) тухайн эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт хүлээж авсан Оролцогч улсын буюу түүний засаг захиргааны нэгжийн хууль тогтоомж, эсхүл дүрэм журмын дагуу дээд боловсролын эрдмийн зэргийн цолыг ашиглах эрхийг уг эрдмийн зэргийг эзэмшигчид олгоно.

Түүнчлэн, үнэлгээ хийж, хүлээн зөвшөөрснөөр эрдмийн зэрэг бүхий өргөдөл гаргагчдад тухайн эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт хүлээж авсан Оролцогч улсын буюу түүний засаг захиргааны нэгжийн хууль тогтоомж, эсхүл дүрэм журмын дагуу хөдөлмөр эрхлэлтийн боломж хайхад дэмжлэг болж болно.

5. Хүлээн зөвшөөрөх эрх бүхий байгууллага хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт гаргагдсан эрдмийн зэрэг болон хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт хүлээж авсан



Оролцогч улсын ижил төрлийн эрдмийн зэргийн хооронд үлэмж ялгаа байгааг нотолж чадах тохиолдолд хүлээн зөвшөөрөх эрх бүхий тухайн байгууллага уг эрдмийн зэргийг хэсэгчлэн хүлээн зөвшөөрч болох эсэхийг тогтоохыг оролдно.

6. Оролцогч улс бүр хил дамнасан боловсролын хөтөлбөрийн хүрээнд олж авсан эсхүл тухайн Оролцогч улсын харьяалалд үйл ажиллагаа явуулж буй гадаадын боловсролын байгууллагаас олгосон дээд боловсролын эрдмийн зэргийг тухайн Оролцогч улсын буюу түүний засаг захиргааны нэгжийн хууль тогтоомж буюу дүрэм журмын тодорхой шаардлагыг мөрдөх эсхүл тухайн боловсролын байгууллагыг үүсгэн байгуулсан Оролцогч улстай байгуулсан тодорхой хэлэлцээрийг мөрдөх нөхцөлөөр хүлээн зөвшөөрч болно.

VI зүйл. Хэсэгчилсэн сургалт болон өмнөх сургалтыг хүлээн зөвшөөрөх

1. Хэсэгчилсэн сургалт эсхүл өмнөх сургалт ба хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт хүлээн авсан Оролцогч улсын дээд боловсролын хөтөлбөрт тухайн хэсэгчилсэн эсхүл өмнөх сургалтын орлох тэр хэсгийн хооронд үлэмж ялгаа байхгүй тохиолдолд Оролцогч улс бүр өөр Оролцогч улсад олж авсан баримтжуулсан буюу гэрчлүүлсэн хэсэгчилсэн сургалт эсхүл баримтжуулсан буюу гэрчлүүлсэн өмнөх сургалтыг Оролцогч улсуудын боловсрол эзэмших боломжтой холбоотой хууль тогтоомжийг харгалзан үзэж дээд боловсролын хөтөлбөрийг дүүргэх эсхүл дээд боловсролын сургалтыг үргэлжлүүлэх зорилгоор аль зохих тохиолдолд хүлээн зөвшөөрч болно. Аль эсхүл, энэ нь өөр Оролцогч улсад баримтжуулсан буюу гэрчлүүлсэн хэсэгчилсэн сургалтад эсхүл баримтжуулсан буюу гэрчлүүлсэн өмнөх сургалтад хамрагдсан хувь хүний хувьд түүний хүсэлтийг үндэслэн уг хэсэгчилсэн сургалт эсхүл өмнөх сургалтын үнэлгээг Оролцогч улс хийхэд хангалттай байна.

2. Чанарын баталгаажуулалтын харьцуулах боломжтой механизмд хамаарах бөгөөд аль нэг Оролцогч улсын дээд боловсролын тогтолцооны нэг хэсэг хэмээн тооцогдох сургалтын уламжлалт бус хүлээн зөвшөөрөгдсөн аргаар олгосон дээд боловсролын хөтөлбөрийг хэсэгчлэн дүүргэснийг баримтжуулсан буюу гэрчлүүлсний үнэлгээг тухайн Оролцогч улсын буюу түүний засаг захиргааны нэгжийн дүрэм, журмын дагуу, сургалтын уламжлалт аргаар олгосон хэсэгчилсэн сургалтад хэрэглэдэг шалгуурыг ашиглан хийнэ.

3. Олон улсын хамтарсан эрдмийн зэрэг олгодог хил дамнасан боловсролын хүрээнд олж авсан, эсхүл наад зах нь нэг улс нь энэхүү Конвенцын Оролцогч улс болох нэгээс дээш улсад хэрэгжүүлсэн хамтарсан аливаа бусад хөтөлбөрийн хүрээнд олж авсан дээд боловсролын хөтөлбөрийг хэсэгчлэн дүүргэснийг баримтжуулсан буюу гэрчлүүлсний үнэлгээг тухайн



Оролцогч улсын буюу түүний засаг захиргааны нэгжийн дүрэм, журмын дагуу, нэг улсад олж авсан хэсэгчилсэн сургалтад хэрэглэдэг шалгуурыг ашиглан хийнэ.

VII зүйл. Дүрвэгсэд ба шилжин суурьшсан этгээдийн хамрагдсан хэсэгчилсэн сургалт ба эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх

Дүрвэгсэд ба шилжин суурьшсан этгээд дээд боловсролд хамрагдах, дээд боловсролын хөтөлбөрийг үргэлжлүүлэх, эсхүл ажил хөдөлмөр эрхлэх боломж хайхад тавигдах зохих шаардлагыг хангасан эсэхийг шударгаар, үр дүнтэй үнэлэх оновчтой журам боловсруулах талаар Оролцогч улс бүр боловсролын тогтолцооныхоо хүрээнд Үндсэн хууль, хууль тогтоомж болон зохицуулалтын заалтдаа нийцүүлэн шаардлагатай, хэрэгжихүйц арга хэмжээг авах бөгөөд үүнд бусад улсад олж авсан хэсэгчилсэн сургалт, өмнөх сургалт буюу эрдмийн зэргийг нотлох баримтаар нотолж чадахгүй байгаа тохиолдлыг багтаана.

VIII зүйл. Үнэлгээ хийхэд болон хүлээн зөвшөөрөхөд шаардлагатай мэдээлэл

1. Оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ олгодог эрдмийн зэрэг болон сургалтын үр дүнг бүрэн гүйцэд тодорхойлох боломжтой ил тод тогтолцоог бүрдүүлнэ.
2. Оролцогч улс бүр дээд боловсролын тогтолцоонд нь итгэх итгэл, үнэмшлийг нэмэгдүүлэх үүднээс дээд боловсролын байгууллагууддаа зөвшөөрөл олгох, хүлээн зөвшөөрөх, чанарын баталгаа олгох бодитой, найдвартай тогтолцоог Үндсэн хууль, хууль тогтоомж болон зохицуулалтын байдал, бүтцэдээ тулгуурлан боломжит хэмжээнд бүрдүүлнэ.
3. Оролцогч улс бүр дээд боловсролын тогтолцооныхоо тухай холбогдох, үнэн зөв, цаг үеийн мэдээллийг хүртээмжтэй байлгах үүднээс үндэсний мэдээллийн төв эсхүл түүнтэй төстэй бүтцийг байгуулж, ажиллуулна.
4. Оролцогч улс бүр мэдээллийг хялбараар авах боломжийг хангах үүднээс технологи ашиглахыг хөхиүлэн дэмжинэ.
5. Оролцогч улс бүр:
 - (a) Зохих тохиолдолд дээд боловсролын тогтолцоо, эрдмийн зэрэг, чанарын баталгаажуулалт, эрдмийн зэргийн цар хүрээнийхээ талаар албан ёсны, үнэн зөв мэдээлэл авах боломжоор хангана;
 - (b) Бусад Оролцогч улсын дээд боловсролын тогтолцоо, эрдмийн зэрэг, дээд боловсрол олж авах боломж олгох эрдмийн зэргийн талаар үнэн зөв мэдээлэл түгээх болон авах нөхцөлийг хөнгөвчлөн дэмжинэ;



(с) Дээд боловсролын эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх асуудлаар, түүний дотор эрдмийн зэргийг үнэлэх шалгуур, журмын талаар болон эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх сайн туршлагатай холбоотой материалыг тухайн хууль тогтоомж, дүрэм журам, бодлогынхоо дагуу бэлтгэж бүрдүүлэх талаар зохих тохиолдолд зөвлөгөө, мэдээлэл өгнө;

(d) Дээд боловсролын тогтолцоонд нь хамаардаг боловсролын байгууллагаас олгосон эрдмийн зэргийн чанар нь хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт хүлээн авсан Оролцогч улсад хүлээн зөвшөөрөгдөх үндэслэлтэй эсэхийг тодорхойлох боломжийг бусад Оролцогч улсын эрх бүхий байгууллагад олгох зорилгоор аливаа тэдгээр байгууллага эсхүл тэдгээр байгууллагын хэрэгжүүлдэг аливаа хөтөлбөрийн талаар шаардлагатай мэдээллийг боломжит хугацаанд өгөх нөхцөлийг бүрдүүлнэ.

IX зүйл. Өргөдлийг үнэлэх

1. Шаардлагатай мэдээлэл гаргаж өгөх үүрэг хариуцлага нь нэн тэргүүнд өргөдөл гаргагчийн үүрэг хариуцлага мөн бөгөөд өргөдөл гаргагч нь уг мэдээллийг үнэнч шударгаар бүрдүүлж өгнө.

2. Оролцогч улс бүр боловсролын тогтолцоонд нь хамаарах байгууллагууд нь эрдмийн зэрэг эзэмшигчид эсхүл хүлээн зөвшөөрөх хүсэлт хүлээн авсан Оролцогч улсын хүлээн зөвшөөрөх эрх бүхий байгууллагад холбогдох мэдээллийг боломжийн хэмжээнд, хүсэлтээр нь, боломжит хугацаанд, үнэ төлбөргүйгээр гаргаж өгөх нөхцөлийг хангана.

3. Оролцогч улс бүр хүлээн зөвшөөрөх үнэлгээ хийж буй байгууллага нь өргөдөл шаардлага хангаагүй шалтгааныг эсхүл үлэмж ялгаа байгааг тодорхойлсон үндэслэлийг гарган харуулж байх нөхцөлийг хангана.

X зүйл. Хүлээн зөвшөөрөх эрх бүхий байгууллагын талаарх мэдээлэл

1. Оролцогч улс бүр хүлээн зөвшөөрөх асуудлаар шийдвэр гаргадаг өөрийн харьяалалд буй эрх бүхий байгууллагын талаарх албан ёсны мэдэгдлийг энэхүү Конвенцын эх хадгалагчид хүргүүлнэ.

2. Оролцогч улсад хүлээн зөвшөөрөх эрх бүхий төв байгууллага байдаг бол тэдгээр нь энэхүү Конвенцын заалтыг нэн даруй дагаж мөрдөх бөгөөд тухайн Оролцогч улсын харьяаллын хүрээнд энэхүү Конвенцын заалтын хэрэгжилтийг хангахад шаардлагатай арга хэмжээг авна.

3. Хүлээн зөвшөөрөх асуудлаар шийдвэр гаргах эрх хэмжээг засаг захиргааны нэгжүүд нь эдэлдэг бол тухайн Оролцогч улс засаг захиргааны

нөхцөл байдал болон бүтцийнхээ талаар энэхүү Конвенцод гарын үсэг зурах үедээ эсхүл соёрхон баталсан тухай батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, баталсан, нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулах үедээ, мөн түүнээс хойших аливаа өөрчлөлтийн талаар Конвенцын эх хадгалагчид товч мэдээлэл хүргүүлнэ. Ийм тохиолдолд засаг захиргааны нэгжийн ийнхүү томилогдсон хүлээн зөвшөөрөх эрх бүхий байгууллага нь Оролцогч улсын засаг захиргааны нөхцөл байдал болон бүтцийн хүрээнд боломжийн хэмжээнд энэхүү Конвенцын заалтын хэрэгжилтийг тухайн Оролцогч улсын харьяаллын хүрээнд хангахад шаардлагатай арга хэмжээг авна.

4. Хүлээн зөвшөөрөх асуудлаар шийдвэр гаргах эрх хэмжээг дээд боловсролын байгууллага эсхүл бусад байгууллага эдэлдэг бол Оролцогч улс бүр буюу тэдгээрийн засаг захиргааны нэгж нь засаг захиргааны нөхцөл байдал буюу бүтцэдээ нийцүүлэн энэхүү Конвенцын эх бичвэрийг тэдгээр байгууллагад хүргүүлж, Конвенцын заалтыг зохих ёсоор авч үзэн хэрэглэхийг хөхиүлэн дэмжих талаар шаардлагатай бүх арга хэмжээг авна.

5. Энэ зүйлийн 2, 3, 4 дэх хэсгийг энэхүү Конвенцын дагуу Оролцогч улсуудын хүлээсэн үүрэгт *mutatis mutandis* хэрэглэнэ.

XI зүйл. Дээд боловсролын хөтөлбөрт элсэхэд тавих нэмэлт шаардлага

1. Дээд боловсролын тодорхой хөтөлбөрт элсэхэд элсэлтийн ерөнхий шаардлагаас гадна тодорхой нэмэлт шаардлага хангахыг шаарддаг бол тухайн Оролцогч улсын эрх бүхий байгууллага нь бусад Оролцогч улсад олж авсан эрдмийн зэрэг эзэмшигчдэд мөн адил тусгай нэмэлт шаардлагаа тавьж болно, эсхүл бусад Оролцогч улсад олж авсан эрдмийн зэрэг бүхий өргөдөл гаргагч нь мөн адил шаардлагыг хангаж буй эсэхийг үнэлж болно.

2. Хэрэв нэг Оролцогч улсад дээд боловсролын байгууллагад элсэх эрдмийн зэргийг олгохдоо ийнхүү элсэхийн тулд эрдмийн зэргийн нэмэлт шалгалт өгсөн байх шаардлага тавьдаг бол бусад Оролцогч улс дээрх шаардлагыг хангасны үндсэн дээр элсэлтийг хэрэгжүүлж болно, эсхүл өөрийн боловсролын тогтолцооны хүрээнд ийм нэмэлт шаардлагыг хангах өөр аргыг санал болгож болно.

3. IV зүйлийн заалтад харшлахгүйгээр, тухайн дээд боловсролын байгууллага буюу уг байгууллагын аль нэг хөтөлбөрт элсэх явц нь шударга, ил тод журмын дагуу хязгаарлагдмал эсхүл сонголтоор хэрэгждэг байж болно.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсгийн тухайд элсэлтийн журам нь гадаад улсын эрдмийн зэргийн үнэлгээг III зүйлд заасан ил тод, шударга, алагчлалаас ангид байх зарчмын дагуу явуулах нөхцөлийг хангасан байна.



5. IV зүйлийн заалтад харшлахгүйгээр, тухайн дээд боловсролын байгууллагад элсэхийн тулд эрдмийн зэрэг эзэмшигч нь тухайн байгууллагын ашигладаг нэг буюу хэд хэдэн хэл эсхүл тусгайлан заасан өөр хэлний хангалттай чадвартай болохоо харуулсан байх нөхцөлийг тавьж болно.

6. Дээд боловсролын хөтөлбөрт элсүүлэх зорилгоор Оролцогч улс бүр өөрийн харьяалалд нь үйл ажиллагаа явуулдаг гадаадын боловсролын байгууллагаас олгосон эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөхдөө өөрийн буюу засаг захиргааны нэгжийн хууль тогтоомж, дүрэм журмын тодорхой шаардлагыг эсхүл тухайн боловсролын байгууллагыг үүсгэн байгуулсан Оролцогч улстай байгуулсан тодорхой хэлэлцээрийг хэрэгжүүлэх нөхцөлийг тавьж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ. ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮТЭЦ БА ХАМТЫН АЖИЛЛАГАА

XII зүйл. Хэрэгжүүлэх бүтэц

Оролцогч улсууд энэхүү Конвенцыг дараах бүтцээр дамжуулан, мөн дараах бүтэцтэй хамтран ажиллаж хэрэгжүүлэхээр тохиролцов. Үүнд:

1. Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх бүтэц;
2. Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх бүтцийн сүлжээ;
3. Эрдмийн зэргийн магадлан итгэмжлэл, чанарын баталгаажуулалт, мэргэжлийн цар хүрээ, хүлээн зөвшөөрөх чиг үүрэгтэй үндэсний, бүс нутгийн, дэлхий дахины байгууллагууд;
4. Оролцогч улсуудын Засгийн газар хоорондын бага хурал;
5. Хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенцын хороод.

XIII зүйл. Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх бүтэц

1. Дээд боловсролын эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх ажиллагааг хөнгөвчлөн дэмжих зорилгоор Оролцогч улсууд энэхүү Конвенцыг үндэсний мэдээллийн төв буюу ижил төстэй байгууллага зэрэг холбогдох байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

2. Оролцогч улс бүр үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх бүтэц болон түүнд орсон өөрчлөлтийн талаар Оролцогч улсуудын Засгийн газар хоорондын бага хурлын Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэнэ.

3. Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх бүтэц нь сүлжээ үүсгэж, түүндээ идэвхтэй оролцох нь зүйтэй.

XIV зүйл. Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх бүтцийн сүлжээ

1. Оролцогч улсуудын Засгийн газар хоорондын бага хурлын ивээл доор сүлжээд нь Оролцогч улсуудын үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх бүтцээс бүрдэх бөгөөд энэхүү Конвенцыг бодит амьдралд хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлж, дэмжиж ажиллана.
2. Сүлжээд нь Оролцогч улсуудад хүсэлтийнх нь дагуу мэдээлэл солилцох, чадавхыг бэхжүүлэх, техникийн дэмжлэг туслалцаа үзүүлнэ.
3. Сүлжээд нь энэхүү Конвенцын хүрээнд бүс нутаг хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэхийг эрмэлзэж, Оролцогч улсуудын Засгийн газар хоорондын бага хуралтай уялдаа холбоотой ажиллана.
4. Оролцогч улсууд нь хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенцоор байгуулагдан үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн сүлжээнд оролцож, эсхүл шинээр сүлжээ байгуулж болно. Бүс нутгийн одоогийн сүлжээнд оролцохдоо тухайн бүс нутгийн хүлээн зөвшөөрөх тухай конвенцын хорооны зөвшөөрлийг авна.

XV зүйл. Оролцогч улсуудын Засгийн газар хоорондын бага хурал

1. Оролцогч улсуудын Засгийн газар хоорондын бага хурал (цаашид “Бага хурал” гэх)-ыг байгуулна.
2. Бага хурал нь энэхүү Конвенцын Оролцогч бүх улсын төлөөлөгчдөөс бүрдэнэ.
3. Энэхүү Конвенцын Оролцогч бус улсуудыг болон хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенцын хороодын тэргүүнийг Бага хурлын хуралдаанд ажиглагчаар урьж оролцуулна.
4. Олон улсын болон бүсийн нутгийн холбогдох байгууллагын төлөөлөгчид, түүнчлэн дээд боловсролын эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх чиглэлээр ажилладаг Засгийн газрын болон төрийн бус байгууллагын төлөөлөгчдийг Бага хурлын хуралдаанд ажиглагчаар урьж оролцуулж болно.
5. Бага хурал наад зах нь хоёр жил тутамд ээлжит хуралдаан зохион байгуулна. Ээлжит бус хуралдааныг Бага хурал тийнхүү шийдвэрлэснээр эсхүл Оролцогч улсуудын гуравны нэгээс доошгүй хувийн хүсэлтээр хийж болно. Бага хурал нь хуралдааны хооронд хэрэгжүүлдэг үйл ажиллагааны урьдчилсан хөтөлбөртэй байна. Бага хурал нь ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлын ээлжит чуулган бүрд тайлан бэлтгэж хүргүүлнэ.
6. Бага хурал энэхүү Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш хоёр жилийн дотор анхдугаар хуралдаанаа хийх бөгөөд уг хуралдаанаар өөрийн дэгийн горимыг батална.



7. Бага хурал энэхүү Конвенцыг хэрэглэхийг хөхиүлэн дэмжиж, дэлхий дахины эсхүл бүс нутгийн түвшний зөвлөмж, тунхаглал, сайн туршлагын загвар, аливаа нэмэлт холбогдох баримт бичиг батлах замаар Конвенцын хэрэгжилтийг хянана.

8. Бага хурал хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенцын хороодтой зөвлөлдсөний үндсэн дээр энэхүү Конвенцын Оролцогч улсуудад зориулан үйл ажиллагааны удирдамж баталж болно.

9. Энэхүү Конвенцын хэрэгжилттэй холбогдуулж ЮНЕСКО-ийн удирдах байгууллага хяналт шинжилгээ хийх, түүнд тайлагнахтай холбогдох үйл ажиллагааг Бага хурал дэмжинэ.

10. Бага хурал хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенцын хороодтой ЮНЕСКО-ийн ивээл доор хамтран ажиллана.

11. Бага хурал болон хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенцын хороод хоорондын шаардлагатай мэдээлэл солилцоог Бага хурал хангана.

12. Бага хурал XIII зүйлийн дагуу батлах энэхүү Конвенцод оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хянаж үзнэ. Батлагдсан нэмэлт, өөрчлөлт нь энэхүү Конвенцод заасан ил тод, шударга, цаг үеэ олсон, алагчлалаас ангид байх зарчмыг бууруулж болохгүй.

13. Бага хурлын Нарийн бичгийн дарга нарын газрыг ЮНЕСКО-ийн Ерөнхий захирал хангана. Нарийн бичгийн дарга нарын газар нь Бага хурлын баримт бичгийг бэлтгэж, хуралдааны хэлэлцэх хэргийг боловсруулж, Бага хурлын шийдвэрийн хэрэгжилтийг хангана.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ

XVI зүйл. Гишүүн улсууд соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах

1. ЮНЕСКО-ийн Гишүүн улсууд ба Гэгээн Ширээт Улс энэхүү Конвенцыг өөрсдийн Үндсэн хуулийн ба хууль тогтоомжийн холбогдох журмын дагуу соёрхон батална эсхүл хүлээн зөвшөөрнө эсхүл батална.

2. Соёрхон баталсан тухай батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, баталсан тухай баримт бичгийг ЮНЕСКО-ийн Ерөнхий захиралд хадгалуулна.

XVII зүйл. Нэгдэн орох

1. Энэхүү Конвенц нь ЮНЕСКО-ийн Гишүүн улс биш боловч Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гишүүн бүх улс нэгдэн ороход нээлттэй бөгөөд тэдгээрийг ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурал нэгдэн орохыг урьж байна.



2. Өөртөө засах бүрэн эрхтэй бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллагаас тийнхүү хүлээн зөвшөөрөгдсөн боловч Ерөнхий Ассамблейн 1514 (XV) дүгээр тогтоолын дагуу тусгаар тогтнолоо бүрэн олж аваагүй болон энэхүү Конвенцын зохицуулах асуудлаар эрх хэмжээтэй (түүний дотор тэдгээр асуудлаар гэрээ байгуулах эрх хэмжээтэй) нутаг дэвсгэрүүд нэгдэн ороход энэхүү Конвенц мөн нээлттэй байна.

3. Конвенцод нэгдэн орсон тухай баримт бичгийг ЮНЕСКО-ийн Ерөнхий захиралд хадгалуулна.

XVIII зүйл. Хүчин төгөлдөр болох

1. Энэхүү Конвенц нь конвенцыг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай хорь дахь батламж жуух бичиг эсхүл баримт бичгийг хадгалуулсан өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болох бөгөөд гэхдээ энэ нь тухайн өдөр, эсхүл түүнээс өмнө соёрхон баталсан тухай холбогдох батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай холбогдох баримт бичгээ хадгалуулсан Оролцогч улсуудад хамаарна.

2. Бусад Оролцогч улсын хувьд тус Конвенцыг соёрхон баталсан тухай батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулснаас хойш гурван сарын дараа энэхүү Конвенц хүчин төгөлдөр болно.

XIX зүйл. Конвенцын Оролцогч улсууд болон хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенц, бусад гэрээний талуудын хоорондын харилцаа

1. Энэхүү Конвенцыг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл нэгдэн ороход хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн аливаа конвенцыг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон байхыг шаардахгүй.

2. Энэхүү Конвенцын Оролцогч улсууд:

(а) Энэхүү Конвенц болон өөрийн нэгдэж орсон бусад гэрээ, ялангуяа хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенц хоорондын харилцан дэмжлэгийг хөхиүлэн дэмжинэ;

(б) Өөрийн нэгдэж орсон хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенцыг тайлбарлах болон хэрэглэхдээ, эсхүл олон улсын бусад үүрэг хариуцлагыг хүлээхдээ энэхүү Конвенцын холбогдох заалтыг харгалзан үзнэ.

3. Энэхүү Конвенцын аль ч заалтыг Оролцогч улсын нэгдэж орсон хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенц болон аливаа бусад гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг нь өөрчилж буй хэмээн тайлбарлахгүй.

4. Энэхүү Конвенц, хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенц, хоёр талт буюу олон талт холбогдох аливаа бусад хэлэлцээр болон энэхүү Конвенцын Оролцогч улсын нэгдэж орсон байж болох эсхүл нэгдэж орж болох хүчин төгөлдөр үйлчилж байгаа буюу ирээдүйд хүчин төгөлдөр болох аливаа бусад гэрээ, конвенц хоорондын уялдаа холбоог хангах зорилгоор, эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөхтэй холбоотой илүү тааламжтай заалт, ялангуяа үндэсний мэдээллийн төв, сүлжээ, үлэмж ялгааны тухай илүү тааламжтай заалтыг үгүйсгэж буй хэмээн энэхүү Конвенцын аль ч заалтыг үзэхгүй.

XX зүйл. Холбооны буюу нэгдмэл бус Үндсэн хуулийн тогтолцоо

Олон улсын хэлэлцээр нь Оролцогч улсуудын Үндсэн хуулийн тогтолцооноос үл хамааран бүгдэд ижил тэгш заавал биелүүлэх хүчинтэйг хүлээн зөвшөөрөхийн хамт холбооны буюу нэгдмэл бус Үндсэн хуулийн тогтолцоотой Оролцогч улсуудад дараах заалт үйлчилнэ. Үүнд:

(a) энэхүү Конвенцын заалтын хэрэгжилт хууль тогтоох холбооны эсхүл төв эрх мэдлийн эрх зүйн харьяалалд хамаарах тохиолдолд улс орнууд дахь болон холбооны эсхүл төв Засгийн газрын үүрэг нь холбооны бус Оролцогч улсуудынхтай ижил байна;

(b) энэхүү Конвенцын заалтын хэрэгжилт Оролцогч улсын засаг захиргааны нэгжүүд, тухайлбал, аймаг, муж, тойрог, дүүргийн эрх зүйн харьяалалд хамаарах тохиолдолд бөгөөд тэдгээр засаг захиргааны нэгж нь холбооны Үндсэн хуулийн тогтолцоо ёсоор хууль тогтоох арга хэмжээ авах үүрэггүй тохиолдолд холбооны Засгийн газар нь дээрх заалтын талаар Оролцогч улсын засаг захиргааны нэгжийн эрх бүхий байгууллагад шаардлагатай тохиолдолд мэдээлж, тэдгээрийг батлах зөвлөмжийг хамт хүргүүлнэ.

XXI зүйл. Конвенцоос гарах

1. Энэхүү Конвенцын аливаа Оролцогч улс энэхүү Конвенцоос хэдийд ч гарч болно.
2. Конвенцоос гарах тухай мэдэгдлийг ЮНЕСКО-ийн Ерөнхий захиралд бичгээр хүргүүлж, хадгалуулна.
3. Конвенцоос гарах мэдэгдлийг хүлээн авснаас хойш 12 сарын дараа Конвенцоос гарах шийдвэр хүчин төгөлдөр болно. Энэ нь Конвенцоос гарах мэдэгдэл хүчин төгөлдөр болох өдөр хүртэл тус Конвенцоос гарсан Оролцогч улсын уг Конвенцын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагыг ямарваа байдлаар хөндөхгүй.

4. Энэхүү Конвенцоос гарах нь дараах зүйлд ямарваа нөлөө үзүүлэхгүй.
Үүнд:

(a) Энэхүү Конвенцын заалтын дагуу өмнө гаргасан хүлээн зөвшөөрөх тухай шийдвэр;

(b) Энэхүү Конвенцын дагуу явцдаа байгаа хүлээн зөвшөөрөхтэй холбоотой үнэлгээ.

XXII зүйл. Эх хадгалагчийн чиг үүрэг

Энэхүү Конвенцын эх хадгалагч болохын хувьд ЮНЕСКО-ийн Ерөнхий захирал нь дараах зүйлийн талаар ЮНЕСКО-ийн Гишүүн улсууд, XVII зүйлд заасан Гишүүн бус улсууд болон Нэгдсэн Үндэстний Байгууллагад мэдээлнэ. Үүнд:

(a) XVI ба XVII зүйлд заасан соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай бүх батламж жуух бичиг буюу баримт бичгийг хадгалуулсан талаар;

(b) XXI зүйлд заасны дагуу Конвенцоос гарсан тухай;

(c) XXIII зүйлийн дагуу баталсан Конвенцод оруулсан нэмэлт өөрчлөлт болон XXIII зүйлд заасны дагуу нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болох өдрийн тухай.

XXIII зүйл. Нэмэлт өөрчлөлт

1. Энэхүү Конвенцын аливаа Оролцогч улс Конвенцод нэмэлт өөрчлөлт оруулах саналаа ЮНЕСКО-ийн Ерөнхий захиралд бичгээр хүргүүлж болно. Ерөнхий захирал уг саналыг бүх Оролцогч улсад тараана. Хэрэв уг саналыг хүргүүлснээс хойш зургаан сарын дотор Конвенцын Оролцогч улсуудын тэн хагасаас доошгүй хувь уг саналыг дэмжсэн бол Ерөнхий захирал уг саналыг Оролцогч улсуудын Засгийн газар хоорондын бага хурлын дараагийн хуралдаанд танилцуулан хэлэлцүүлж, батлах эсэхийг шийдвэрлүүлнэ.

2. Нэмэлт өөрчлөлтийг хуралд оролцож, саналаа өгсөн Оролцогч улсуудын гуравны хоёр хувийн саналаар батална.

3. Энэхүү Конвенцод оруулах нэмэлт өөрчлөлтийг баталсны дараа Оролцогч улсуудад соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл нэгдэн орох шийдвэр гаргуулахаар хүргүүлнэ.

4. Энэхүү Конвенцод орсон нэмэлт өөрчлөлтийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон Оролцогч улсуудын

хувьд уг нэмэлт өөрчлөлт нь энэ зүйлийн 3 дахь хэсэгт тусгасан батламж жуух бичиг эсхүл баримт бичгийг Оролцогч улсуудын гуравны хоёр нь хадгалуулснаас хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно. Түүнээс хойш, нэмэлт өөрчлөлтийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан эсхүл нэгдэн орсон Оролцогч улс бүрийн хувьд тухайн Оролцогч улс уг нэмэлт өөрчлөлтийг соёрхон баталсан тухай батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулсан өдрөөс хойш гурван сарын дараа уг нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болно.

5. Энэ зүйлийн 4 дэх хэсгийн дагуу нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болсны дараа Конвенцын Оролцогч улс болсон улс нь өөр санаатай байгаагаар илэрхийлээгүй бол тухайн улсыг:

(a) Нэмэлт өөрчлөлт орсон Конвенцын Оролцогч улс; бөгөөд

(b) Нэмэлт өөрчлөлтийг заавал дагаж мөрдөхгүй аливаа Оролцогч улстай холбогдуулж нэмэлт өөрчлөлт ороогүй Конвенцын Оролцогч улс

гэж тооцно.

XXIV зүйл. Нэгдсэн Үндэстний Байгууллагад бүртгүүлэх

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн 102 дугаар зүйлд заасны дагуу энэхүү Конвенцыг ЮНЕСКО-ийн Ерөнхий захирлын хүсэлтээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газарт бүртгүүлнэ.

XXV зүйл. Жинхэнэ эх бичвэр

Энэхүү Конвенцыг англи, араб, испани, орос, франц, хятад хэлээр боловсруулсан бөгөөд зургаан эх бичвэр бүгд адил хүчинтэй.

---o0o---

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeleel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 10.5

Индекс: 200003